

## ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 07 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### **Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:**

Монголын тулгар төрийн 2226, Их Монгол улс байгуулагдсаны 811, Ардын хувьсгалын 96 жилийн ойн баярыг 7 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлээ.

Аймгийн Онцгой комисс хуралдаж энэ жил гандуу, гантай жил болж байгаа учир өвөлжилт хүндэрч болзошгүй гэж үзэн аймгийн хэмжээнд хадлан тэжээлээ эртнээс бэлтгэх, нөөцлөх ажлыг шуурхай зохион байгуулах хэрэгтэй гэж үзлээ.

Мөн аймгийн Онцгой комиссын гишүүдийг хандлангийн бүс нутгуудад газар дээр нь очиж ажиллах, хадлан тэжээлийн гарц хэр байгааг тогтоон, тулгамдаж буй асуудлыг шуурхай шийдвэрлэхийг аймгийн Засаг дарга бөгөөд аймгийн Онцгой комиссын дарга Д.Галсандондог үүрэг болгов.

Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг дарга 12 өргөдөл бичгээр хүлээн авч, 10 өргөдлийг шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт 4 өргөдөл бичгээр хүлээн авч, 3 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж нийт өргөдлийн шийдвэрлэлт 81.3 хувьтай байна. Төрийн албаны зөвлөлийн аймгийн салбар зөвлөлд өргөдөл бүртгэгдээгүй болно.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 1 сувгаар 3 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 3 санал хүсэлт ирүүлснээс гомдол 2, санал хүсэлт 1 бүртгэж холбогдох хэлтэс, тасгийн дарга нарт шилжүүлж, 3 иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэж, шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг “Саналын хайрцгаар өргөдөл хүлээн авах журам”-ын дагуу энэ сард санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 3 гомдол, 7 санал хүсэлт хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж шийдвэрлүүлэн хариу илгээж, шийдвэрлэлт 100 хувьтай байна.

### **Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:**

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 7 дугаар сарын санхүүжилтийг олгож, цалин хөлс, тогтмол зардал, зарим зайлшгүй гарах зардлуудыг хугацаанд нь санхүүжүүлээ.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл эхний хагас жилийн байдлаар орон нутгийн төсвийн орлогод 4664,0 сая төгрөг орж төлөвлөгөө 49,0 сая төгрөгөөр буюу 1,0 хувиар тасарсан байна. Үүнээс татварын орлогод 3564,7 сая төгрөг орж төлөвлөгөө 12,2 сая төгрөгөөр буюу 0,3 хувиар давж, татварын бус орлогод 367,6 сая төгрөг оруулж төлөвлөгөө 0,1 сая төгрөгөөр буюу 0,3 хувиар тус тус тасарсан байна.

Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 хувиар илүү биелэсэн байна.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл эхний хагас жилийн байдлаар удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зарлага 10504,2 сая төгрөг хүрч, төлөвлөгөөнөөс 2802,9 сая төгрөгөөр хэмнэлттэй буюу дутуу гарсан байна. Төсвийн өр 144,1 сая, авлага 80,7 сая төгрөг болж оны эхнээс өр 23,1 сая, авлага 31,1 сая төгрөгөөр өссөн байна.

Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын төсвийн зарлага урьдчилсан байдлаар 19493,1 сая төгрөгт хүрч, 513,8 сая төгрөгийн хэмнэлтэй гарсан байна.

Төсвийн өр 322,4 сая, авлага 35,6 сая төгрөг болж оны эхнээс өр 222,7 сая төгрөгөөр өсөж, авлага 160,5 сая төгрөгөөр буурсан байна. Өрийг салбараар авч үзвэл Эрүүл мэндийн салбарын сумдын эрүүл мэндийн төвүүд 43,4 сая, Боловсрол, соёлын салбарын байгууллагуудын өр 271,2, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын өр 1.0 сая, Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтэс 6.8 сая төгрөг тус тус байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 122.0 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1245.5 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 180.0 сая, нийт 1547.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээс орон нутгийн хөрөнгө хөрөнгө оруулалт 106.4 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 40.5 сая, Орон нутгийн хөгжлийн сангаас 941.4 сая, нийт 1088.3 сая төгрөг олгосон нь төсөвлөснөөс санхүүжилт 459.2 сая төгрөгөөр дутуу байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тодотгосон төсвөө баталсан 14 сумын төсөв, сарын хуваарийг байгууллага, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар төсвийн Фискал программд шивж оруулж нэгтгэв.

Орон нутгийн төсвийн 2018 оны төсөл, 2019-2020 оны дунд хугацааны төсөөллийг боловсруулах удирдамж, заавар, хуваарийг боловсруулан сум, байгууллага, хэлтсүүдэд аймгийн Засаг даргын 3 албан бичгээр хүргүүлж, хуваарийн дагуу улс, орон нутгийн, бусад гадны эх үүсвэрийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын болон орон нутгийн төсвийн орлого, зардлын төслийг хүлээн авч нэгтгэж байна.

Орон нутгийн төсвийн 2018 оны төсөл, 2019-2020 оны төсөөлөл боловсруулж байгаатай холбогдон Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Гадаадын иргэн харьяатын газарт албан бичиг хүргүүлж татварын ногдуулалтай холбоотой мэдээллийг гаргуулан орлогын төсвийн төслийг боловсруулж байна.

Төсвийн 42 албан байгууллагаас 594,8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрхийн хүсэлт ирснийг Сангийн яамны төрийн сангийн газарт илгээж санхүүжилтын эрхийг нээлгэж гүйлгээг тухай бүр хийлээ.

Орон нутгийн төсөвт байгууллагуудын 2 дугаар улирлын эхний хагас жилийн санхүүгийн тайланг 17 сум, 201 байгууллагаас цахимаар “Э-тайлан”-д шивүүлж, хянан нэгтгэж байна.

Аймгийн Аж ахуйн нэгж, байгууллагуудын эхний хагас жилийн санхүүгийн тайланг 475 аж ахуйн нэгжээс хянан авч баталгаажуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг аймаг, сум тус бүрээр эхний хагас жил болон 7-р сарын байдлаар гарган аймгийн Засаг даргын орлогч, холбогдох хэлтсийн дарга нарт танилцуулав.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй эрх нь шилжиж ирсэн санхүүжилтыг ажлын гүйцэтгэл, баримтын бүрдлийг шалгаж ЭМС-ын эрх шилжсэн 925.0 сая төгрөг, БСШУС-ын 65.8 сая төгрөгийг бүрэн олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас аймаг, сумдын баяр наадмын санхүүжилтыг сарын эхэнд 64.3 сая төгрөг шилжүүлж, хуваарийн дагуу МЭУСАХ-ны зардал 30.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгоод байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг холбогдох салбар, хэлтсээс саналыг авч, нэгтгэн Засаг даргын орлогчоор хянуулан холбогдох яаманд албан бичгээр хүргүүлээ.

Хагас жилийн байдлаар Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг гарган хугацаанд нь Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг холбогдох мэргэжилтэн, албадаас нь авч нэгтгэн хүргүүлсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газраас санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Орон нутгийн хөгжлийн санд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэхээр ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгө оруулалт, аймаг хөгжүүлэх сангийн авлагын жагсаалтыг 2013-2017 он хүртэл гарган Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, Хууль зүйн хэлтэст албан бичгээр хүргүүлэн, авлага, өглөг барагдуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Энэ сарын байдлаар төрийн сангийн төлбөр тооцооны Freebalance программаар нийт 37 байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 5,6 тэрбум төгрөгийн 811 ширхэг гүйлгээ хийгдсэн байна. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу төрийн сангийн гүйлгээг түргэн шуурхай гүйцэтгэж байна.

Сангийн яамтай хамтран “Орон нутгийн төсөв, санхүүгийн ажилтны чадавхийг бэхжүүлэх” сэдэвт сургалтыг 7 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд зохион явуулж, 17 сумдын санхүү албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогч нийт 70 хүн оролцлоо.

Татварын хэлтэс нь 2017 оны хагас жилийн тайланг 1801 аж ахуйн нэгжийн 1514 ААНОАТ-ын тайланг хүлээн авч 84.0 хувьтай, суутган-1 тайланг 1481-г хүлээн авахаас 1082 тайлан хүлээн авч 73.0 хувьтай, НӨАТ-ийн 2109 тайлан хүлээн авахаас 2095 тайланг өссөн дүнгээр хүлээн авч 99.3 хувьтай, суутгагчийн хувь хүнээс суутгасан 339 тайлан хүлээн авлаа.

Хяналт шалгалтанд ХХК 8, иргэн 2-ыг хамруулан шалгалаа. Шалгасан татвар төлөгч бүрт гаалийн мэдээлэл болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгалт хийснээр шалгалтын явцад 133,3 сая төгрөгийн зөрчилд 13.5 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 4.5 сая төгрөгийн торгууль, 3,3 сая төгрөгийн алданги, нийт 21,3 сая төгрөгийн нөхөн татвар хүү, торгууль, алданги ногдуулж ажиллалаа.

Статистикийн хэлтсээс ажиллах хүчний судалгааг Жаргалант сумын Хайрхан баг, Зэрэг сумын Гүвээ, Эрдэнэбүрэн сумын Баянгол багуудад, өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг Жаргалант сумын Цамбагарав, Булган сумын Далт, Чандмань сумын Жаргалант багуудад нийт 62 өрхөд хийж, судалгааны материалаа хянан шалгаж шивэх шатандаа явж байна.

Аж үйлдвэр, тээвэр холбоо, үйлчилгээний салбарын танилцуулга, хүн ам өрхийн үндсэн үзүүлэлт төлөв байдлын танилцуулгуудыг хийж файлаар төвд дамжуулсан.

Аж ахуйн нэгж байгууллагын судалгаа 18 төрлийн мэдээг 212 аж ахуйн нэгж байгууллагаас авч, шалгаж нэгтгэн онлайнаар шивж ҮСХ-д дамжуулсаны зэрэгцээ, аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулгыг эмхэтгэн гаргаж хэлтэс, агентлагуудын удирдлагуудад хүргүүлэв.

### **Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд:**

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа хууль сахиулах байгууллагуудын удирдлагуудын ээлжит уулзалтыг зохион байгуулж 2018 оны хөрөнгө оруулалтын

төсөв, 2018-2020 оны төсвийн төсөөлөлд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтанд тусгуулах арга хэмжээний талаар чиглэл өглөө.

Хэлтсийн хурлыг 2 удаа хийж, 5 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 2 иргэнд анхан шатны бичиг баримт боловсруулж тусламж үзүүлэв.

Сумдын эрх зүйн ажилтнуудад эрх зүйн ажлын тайлан, мэдээ ирүүлсэн байдал, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт, аяны явцын талаар сургалт зохион байгуулж, сумдаас ирүүлсэн эрх зүйн ажил үйлчилгээний мэдээ тайланд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаар албан бичгээр арга зүйн зөвлөмж, үүрэг чиглэл хүргүүллээ. Мөн Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан нотариатын үүрэг гүйцэтгэгч нараас нотариатын үйлчилгээ үзүүлэх аргачлалыг сумдын Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөнд санал авах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг төлөвлөгөөний төсөл боловсруулан ажлын хэсэг хуралдав.

Архивын тасаг нь 41 дүгээр хөмрөг, 72 дугаар хөмрөгийн 1950-1990 оны 21 ширхэг хадгаламжийн нэгж буюу 1838 хуудсыг цахим хэлбэрт шилжүүлээд байна.

**Цагдаагийн газар:** Иргэд олон нийтэд хууль эрх зүйг сурталчлан таниулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

Сонгуулийн сурталчилгааны үед бусдын хуулиар хамгаалагдсан эрхэнд халдаж гүтгэн доромжлох, Сонгуулийн тухай хууль зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 төрлийн сэрэмжлүүлэг, зөвлөмжийг орон нутгийн 2 телевизээр 3 өдөр, өдөрт 3 удаагийн давтамжтайгаар, нийт 18 удаа нэвтрүүлж цахим сайтуудад уг сэрэмжлүүлэг мэдээллийг видео хэлбэрээр болон бичгээр нийтлүүлж олон нийтэд хүргэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураах өдөр нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гарч болзошгүй тул энэ өдөр архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулахгүй байх талаар аймгийн Засаг даргын 2017 оны А/274 дүгээр захирамж гаргуулан, энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг 82 аж ахуйн нэгжид захирамжийг хэрэгжүүлэх талаар Цагдаагийн газрын мэдэгдлийн хамт хүргүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ мэдээлэл өгч, цахим сайтуудад нийтлүүлсэн.

Мобикомын Ховд салбартай гэрээ байгуулан цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Үндэсний их баяр наадмын үеэр хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үер усны аюулаас сэрэмжлүүлэх чиглэлээр 600 хүнд мессеж илгээв.

Иргэдийн амралт зугаалгын үе эхэлсэнтэй холбогдуулан “Гол”, “Хамтарсан эргүүл”, “Эргүүл-хяналт”, “Хяналт-шалгалт” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулав.

Аймгийн хэмжээнд 07 дугаар сарын 24-ний байдлаар 18 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хулгайлах 8, үүнээс иргэдийн өмчийн хулгай 8, хүний эрүүл мэндэд хүндэвтэр гэмтэл санаатай учруулах 1, бусдыг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 2, хөрөнгө завших 1, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4, хүчиндэх 1, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 1 тус тус бүртгэгдлээ.

Цагдаагийн газар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 85 гомдол мэдээлэл хүлээн авсны гэмт хэрэг 19 буюу 22.4 хувийг гэмт хэргийн талаарх, 66 буюу 77.6 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байгаа бөгөөд зөрчил гаргасан 32 хүнийг албадан саатуулж, 10 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, зөрчил гаргасан 117 хүнийг 7.042.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа.

**Шүүхийн шинжилгээний алба:** Шүүхийн шинжилгээний албанд хандаж 19 албан бичиг, 48 шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж ирүүлснийг хүлээн авч, бүртгэн цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 16 албан бичиг боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Үндэсний их баяр наадмын өдрүүдүүдэд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын б/254 тоот тушаалаар албаны хэмжээнд /2017.07.06-15-ны хооронд/ 9 хоногийн өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, уг өдрүүдэд хүний амь нас хохирсон-1, хулгай-6, зам тээврийн осол-8, бусад-4, нийт 19 гэмт хэргийн газрын үзлэгт оролцсон ба үзлэгээр гарын мөр-9, гутлын мөр-4, тээврийн хэрэгслийн явагч хэсгийн мөр-9 ширхэг тус тус илрүүлж, бэхжүүлэн хураан авах ажиллагаанд оролцож, хэргийн газрын 164 ширхэг гэрэл зураг авч ажилласан. Мөн хугацаанд эрх бүхий албан тушаалтанаас ирүүлсэн шинжилгээ хийлгүүлэх тогтоолыг үндэслэн 2 цогцост задлан шинжилгээ хийсэн.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 8 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 47 хүнд, химийн 21, биологийн 16, криминалистик шинжилгээ 6 тус тус хийж, нийт 100 дүгнэлт гаргаж, алсын дуудлаганд 2 удаа явж ажиллав.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 52 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 37 ширхэг мөр, гутлын мөр 24, тээврийн хэрэгслийн мөр 32, бусад ул мөр, эд мөрийн баримт 57 илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 25, гарын мөр 13-г тус тус авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийв. Криминалистикийн шинжээч нар гэрэл зургийн ажил 701 хийснээс шинжилгээний 47, хэргийн газрын үзлэгийн 340, цогцосны үзлэг задлан шинжилгээний 227, бусад 87 тус тус хийж цагдаагийн байгууллагад хүргүүлсэн.

Албанаас гаргасан шинжилгээнүүдийн дүгнэлтүүдийг тухай бүрт нь цахимжуулав.

Төлбөрт үйлчилгээний орлогод 1.959.500 төгрөг төвлөрүүлээд байна.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба:** Тус алба нь нийт 64 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас 06 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар шийдвэр гүйцэтгэгч 2, дэд бөгөөд гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт хариуцсан дарга 1, нярав 1 нийт 4 албан хаагч томилогдоогүй 60 алба хаагчтай ажиллаж байна.

Тус албаны шинээр баригдах Цагдан хорих байр болон конторын барилгын ажил эхэлсэнтэй холбогдуулан бусдад төлөх өр төлбөртэй нэр бүхий 13 хоригдлыг барилгын туслах ажилтнаар ажиллуулах гэрээ байгуулан ажиллуулж байна. Барилгын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн 2 дахь санал хураалт болон Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан 07 дугаар сарын 06-ны өдрийн 09.00 цагаас өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж нийт бие бүрэлдэхүүнийг албаны бэлэн байдал хангуулах зорилгоор Түгшүүр-1 дохиогоор дуудаж бэлэн байдлыг шалгав. Өндөржүүлсэн бэлэн байдлыг 07 дугаар сарын 16-ны өдрийн 09.00 цагт цуцалж Хорих анги ердийн хамгаалалтанд шилжсэн.

07 дугаар сарын 09-ний өдөр Авдарант дахь Хорих 403 дугаар ангийн хамгаалалтын бүсээс гадуур ажиллаж байхдаа оргон зайлсан хоригдол эрэн сурвалжлах ажлыг аймгийн Цагдаагийн газар болон бусад холбогдох албан байгууллагуудтай хамтран эрэн сурвалжлах ажлыг бүсийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулах хуваарийн дагуу төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний дагуу хорих анги, Говь-Алтай, Баян-Өлгий, Увс аймгийн шийдвэр гүйцэтгэх албадуудын мэдээ, тайланг нэгтгэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар хүргүүлэв.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Ховд аймаг дахь Цагдаагийн газартай хамтран 4 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэлээ.

Болзошгүй ажиллагааны үед ашиглагдах тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад өдөр бүр бичгээр үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавилаа.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Энэ сард нийт 2214 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 1603, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 121 ба шилжин ирсэн иргэд 18, шилжин явсан иргэд 16 иргэн, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 87, гадаад паспорт олголт болон сунгалт 350, иргэний үнэмлэх шинээр олгосон 351, сунгалт 170, дахин олгосон 120, иргэний бүртгэлийн лавлагаа 232 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 259 бүртгэлийг хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 538, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 63 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажилласан.

Иргэдээс нийт 10 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс 3 хуулийн хугацаанд шийдвэрлэж, 7 өргөдлийн хугацаа болоогүй байна.

### **Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:**

**Боловсрол соёлын чиглэлээр:** Аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь 7 дугаар сард дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:

Монголын их дээд сургуульд оюутан элсүүлэх журмын дагуу МИДСК, БСУГ, Ховд их сургуультай хамтран салбар комисс байгуулан МИДСК сургуульд оюутан элсүүлэх, хөтөлбөр сонгуулах үйл ажиллагааг 7 дугаар сарын 3-5 өдрүүдэд Жаргалант сумын 3 дугаар сургууль дээр зохион байгууллаа. Аймагт Магадлан итгэмжлэгдсэн 2108 их, дээд сургууль ирсэнээс 846 хүүхэд хувиар сонголтыг хийсэн.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр баруун аймгуудын Боловсролын газрын мэргэжилтнүүдийг чадавхжуулах “Тогтвортой хөгжлийн боловсрол” сэдэвт уулзалт сургалтыг Дуут сумын “Нэвт” амралтын газар 53 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан туршлага солилцлоо.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 07 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд Улсын анхдугаар Бий биелэгээний наадмыг аймагт амжилттай зохион байгууллаа.

БСШУСЯ-ны сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хагас жилийн биелэлт, аймгийн Засаг даргын үндсэн чиглэлийн биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг тайлангуудыг тус тус хагас жилээр гаргалаа.

Монгол улсын Засгийн газрын хуралдаанаар Байгууллагын цэцэрлэгийг байгуулах талаар санал оруулахтай холбоотой судалгаа, мэдээлийг гаргаж БСШУСЯ-д явууллаа.

Музей гадна, дотны жуулчин аялагчид, ард иргэдэд үйлчилж, улсад 1 сая гаруй төгрөгийн орлого оруулан ажиллав.

Дарви сумын нутагт үл хөдлөх дурсгалын тооллогын ажил зохион байгуулж, 100 гаруй түүхэн дурсгалыг тоолж, бүртгэл мэдээллийн санд баримтжуулав. Мөн энэхүү ажлын явцад тус сумын Мөнгөн аяга, Булаг багуудад үл хөдлөх дурсгалын талаар нутгийн ард иргэдэд мэдээлэл хийсэн бөгөөд 170 гаруй иргэд хамрагдаж, 600 гаруй тараах материал хэвлэн тараав.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Үндэсний их баярын өдрүүдээр Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн А/169, аймгийн Эрүүл мэндийн газрын даргын А/21

дүгээр тушаалын дагуу хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган ажиллаж, мэдээг хугацаанд Эрүүл мэндийн яаманд хүргүүлээ.

Дөргөн, Чандмань, Мянгад сумын эрүүл мэндийн төвүүдэд хяналт үнэлгээ хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. ОНБТБ өгсөн мэдээг Алтай, Үенч сумын эрүүл мэндийн төв, Булган сумын нэгдсэн эмнэлгээс авч нэгтгэн Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлээ.

Түлэгдэлтийн талаарх эцэг эхийн мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх судалгааг шивж дуусгасан. Засаг даргын Тамгын газарт Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хүргүүлж, Засаг даргын зөвлөл, ИТХ-аар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажилласан.

Эрүүл мэндийн газрын барилгын их засварын ажил дууссантай холбоотойгоор нүүлгэх болон их цэвэрлэгээний ажил хийсэн.

Үндэсний их баяр наадамтай холбогдуулан баяр наадмын өдрүүдэд наршилт, даралт ихсэх, усанд живэх, хоолны хордлого, архины хордлого, зам тээврийн осол гэмтлээс сэргийлж, анхаарал болгоомжтой амарч зугаалах, 8-аас дээш сартай жирэмсэн эхчүүд хол замд зорчихгүй байхыг анхааруулсан зөвлөмжийг Эрүүл мэндийн газрын facebook хуудас, аймгийн зарын сайтуудад байршуулж мөн орон нутгийн Ховд телевизээр олон нийтэд хүргэж сурталчилан ажилласан.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс ирсэн 293 тоот албан бичгийн дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих” Дэлхийн долоо хоногийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай албан тоотыг хүргүүлсэн. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 07 сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан 1 өдрийн зайн сургалтанд БОЭТ болон өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг хамруулав.

6 сарын дархлаажуулалтын хамралтын болон зарцуулалтын тайланг Халдварт өвчин судлалын үндэсний төвд, галзуугийн вакцины хамралт, боом, хачигт халдварын вакцины хамралтын тайланг хагас жилийн байдлаар гаргаж Зооноз өвчин судлалын үндэсний төвд хүргүүлж ажилласан.

Нохойнд уруулж ноцуулсан 13 хүнийг галзуу өвчнөөс сэргийлэх вакцинд, үүн дотроо 1 хүүхдийг ийлдэс эмчилгээнд хамруулав.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанаас сайн дураар гаммаглобулин 50 хүн тун, тархвар судлалын заалтаар туберкулины сорил 100 хүн тун, вакцины орлого, зарлагын дэвтэр 20 ширхэгийг захиалан авч сум, өрхүүдэд хүргүүлэхэд бэлэн болсон.

Томуу, томуу төст өвчин болоод халдварт өвчний хам шинж, сэжигтэй өвөрмөц тохиолдлын мэдээг өдөр бүр авч нэгтгэн 7 хоногийн мягмар гараг бүр Томуугийн үндэсний төв болон Халдварт өвчин судлалын үндэсний төвд EWAR 2.0, Health-info 3.0 програмаар цаг хугацаанд нь, 6 сард бүртгэгдсэн халдварт өвчний хам шинж, сэжигтэй өвөрмөц тохиолдлын мэдээг статистикт мэдээлсэн.

“Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй 40-65 насны иргэдийн үзлэгийн мэдээг пүрэв гараг болгон анхан шатны нэгжүүдээс утсаар авч, Баасан гарагт нэгтгэн 4 долоо хоногийн мэдээг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлж ажилласан. 40-65 насны 6353 иргэд шинжилгээнд хамрагдсанаас В вирус илэрсэн 608, С вирус илэрсэн 736, ВС вирус илэрсэн 57, 4952 иргэд эрүүл гарсан байна.

Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ хийх хуваарийн дагуу Мянгад, Дөргөн, Чандмань сумын эрүүл мэндийн төв болон эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага болон хувийн хэвшлийн эмнэлгүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тухай бүр холбогдох мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч, үр дүнгийн хурал хийж, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Эрүүл мэндийн газрын Тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлаар нийт 13 эрүүл мэндийн байгууллагын өргөдөл, холбогдох материалтай танилцан хурлаар 9

байгууллагын эрхийг сунгаж, 1 эрхийг хүчингүй болгож, шинээр эмийн сан-1, хаягийн өөрчлөлт -1, 2 эрүүл мэндийн байгууллагыг түдгэлзүүлэн дахин хурлаар оруулахаар шийдвэрлэлээ.

**Биеийн тамир спортын чиглэлээр:** Биеийн тамир спортын газрын даргын баталсан 2017 оны сургалт бэлтгэлийн хуваарийн дагуу спортын 10 төрлөөр 550 гаруй тамирчин сурагчид зуны бэлтгэл сургуулилтанд хамрагдаж байна. Бэлтгэл 1-5 дахь өдрүүдэд өглөө, өдөр гэсэн 2 ээлжээр хичээллэж байгаа бөгөөд бүс, улсын чанартай тэмцээнүүдэд бэлтгэгдэж байна.

“Алфинад-2017” Уулын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 06 дугаар сарын 28-наас 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд Мөнххайрхан сумын нутагт орших Мөнххайрхан ууланд /Сүхбаатар, Барилгачин оргил далайн түвшинээс дээш 4204 м/ амжилттай зохион байгуулж явууллаа. Энэхүү тэмцээнд Ховд, Баян-Өлгий, Увс, Эрдэнэт, Говь-Алтай, Сэлэнгэ, Дархан аймаг болон Налайх, Хан-Уул дүүргүүдийн 250 гаруй уулчид оролцсон томоохон арга хэмжээ болж өнгөрлөө.

Биеийн тамир спортын газрын түүхт 70 жилийн ойн хүрээнд Урианхай сурын улсын аварга шалгаруулах тэмцээнийг Мөнххайрхан суманд амжилттай зохион байгууллаа. Энэхүү тэмцээнд эрэгтэй 86, эмэгтэй 38 харваач оролцон аваргуудаа тодруулсан байна.

“Эртэч Ховд” аяны өглөөний гүйлт, гимнастик, хийн дасгал, спорт заалны чөлөөт тоглолтын үйл ажиллагаа хуваарийн дагуу хэвийн явагдаж байна.

Ардын хувьсгалын 96 жилийн ойн баярыг зохион байгуулах ажлын хүрээнд төв цэнгэлдэх хүрээлэнгийн дотор, гадна засварын ажлыг хийж дуусган, баяр наадмыг амжилттай зохион байгууллаа.

**Хүүхэд, гэр бүлийн эрх хамгааллын чиглэлээр:**Тулгар төрийн 2226, их Монгол улс байгуулагдсаны 811, Ардын хувьсгалын 96 жилийн ойн үндэсний их баяр наадмын үед унаач хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар сумдад чиглэл хүргүүлж, уяачид болон эцэг эхчүүдэд зориулсан 3 төрлийн 500 ширхэг гарын авлага, зөвлөмж тараасан.

Унаач хүүхдийн бүртгэлийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу унаач хүүхдийн бүртгэлийн зарыг Жаргалант телевиз болон холбогдох сайтуудад байршуулан олон нийтэд зарлаж, Буянт голын Бага гүүрний дээд талд бүртгэлийн цэг байгуулан 80 унаач хүүхдийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд бүртгэж, файл бүртгэлд хүүхдийн нас, хүйс, унаж уралдсан тоо зэрэг үзүүлэлтийг нэгтгэн шивж орууллаа.

Гэнэтийн ослын даатгалыг Монгол, Пракиткал, Номин, Бодь, Монре даатгалын компаниуд хийлээ.

“Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” MNS6264:2011 стандарт болон “Үндэсний их баяр наадмын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг үндэслэн уяач болон эцэг эх, морь унаж байгаа хүүхдийн хороонд гурвалсан хариуцлагын гэрээнүүд хийж, санамж бичигт гарын үсэг зуруулан ажилласан болно.

Уралдаанд нийт 6 насны 319 морийг 80 хүүхэд унаж уралдсан. Уралдааны явцад хүүхэд бэртэж, гэмтсэн явдал гараагүй ч хязгаалан насны морины гарааны үед 1 хүүхэд мориноос унасан бөгөөд тухайн үед ажилласан эмч хүүхдийг үзэж, биед нь ямар нэгэн бэртэл гэмтэлгүй болохыг нь тогтоон эцэг эх болон асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн.

Аймгийн хэмжээнд 11 сум үндэсний их баяр наадмыг тэмдэглэн нийтдээ 1932 хурдан морийг 519 хүүхэд унаж уралдсан байна.

Гэр бүл, хүүхдийн эрх зөрчигдсөн асуудлаар 2017 оны эхний хагас жилд бүртгэгдсэн кейст хариу үйлчилгээ үзүүлж холбон зуучлах, аймаг, сумдын баяр



наадмын үеэр хурдан морины унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах асуудлаар харилцан санал солилцох зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/149 тоот захирамжаар байгуулагдсан Хүүхэд хамгааллын дэд зөвлөлийн гишүүдийн хамтарсан уулзалтыг 07 сарын 06-ны өдөр зохион байгуулж, салбар байгууллагуудын төлөөлөл 30 хүн оролцож, санал бодлоо солилцлоо.

Хүүхэд, гэр бүлтэй холбоотой 2 кейст үйлчилгээ үзүүлэн холбогдох хамтарсан багт шилжүүлэн өгсөн.

**Хүүхэд гэр бүлийн дотоод ажил хяналт үнэлгээний чиглэлээр:** Үндэсний баяр наадмаар зохион байгуулагдсан хүүхдийн бөхийн барилдаанд 15-аас доош насны өсвөрийн 32 бөх хурд хүчээ сорин барилдаж, барилдааны үеэр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллав.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХШҮДАХ-ээс 07 дугаар сарын 19-нд зохион байгуулагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэх нь” сургалтанд байгууллагын дотоод ажил, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн оролцлоо.

**Залуучуудын хөгжлийн чиглэлээр нь:** 07 дугаар сард нийт 15-34 насны 70 өсвөр үе, залуучууд үйлчилгээ авсан ба үүнээс интернэтийн үйлчилгээ 40, сэтгэл зүйн зөвлөгөө 9, сонирхлын клуб болон дэмжих бүлгээр дамжуулан 21 хүн үйлчлүүлсэн байна.

**Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр:** Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг иргэдэд түргэн шуурхай хүргэн, амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Халамжийн тэтгэвэр 1616 хүнд, 1.293.907.010.00, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1889 хүнд 630.777.770.00, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж 837 хүнд 362.624.930.00, ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 4686 хүнд 234.432.460.00, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 1411 хүнд 113.776.780.00, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж 2974 хүнд 460.231.620.00, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж 8690 хүнд 1.190.700,000.00, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 50 хүнд 50.252.300.00, хүнс тэжээл, нийгмийн хамгааллын хөтөлбөрт 5075 хүнд 216.559.000, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ 215 хүнд 7.997.100, насны хишиг 5291 хүнд 446.940.000, Нийт 32734 хүнд 5.008.198.970 төгрөгийг олгосон байна.

**Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн мөнгө, хүнс тэжээл хөтөлбөрийн хүрээнд:** Өрхийн мэдээллийн сангийн судалгааны дагуу амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 3 өрхөд амьжиргааны түвшний тодорхойлолт гаргаж, тус өрхийн 18-аас дээш насны өрхийн гишүүн иргэдийг эрүүл мэндийн даатгалд үнэ төлбөргүй хамрууллаа. Шинэ төрсөн 50 гаруй хүүхдийг өрхийн мэдээллийн санд нэмж бүртгэлээ.

Хүүхдийн мөнгөний олголттой холбоотойгоор иргэдийн хүсэлтийн дагуу мэдээллийг шалгаж, шаардлагатай мэдээллээр хангаж ажиллалаа.

**Ахмад настан, зорилтот бүлгийн чиглэлээр:** Цэцэг, Алтай, Булган суманд бичил уурхай эрхэлж буй зорилтот бүлгийн иргэдэд 07 дугаар сарын 4-7-ны хооронд сургалт зохион байгуулж, “Зорилтот бүлгийн хөгжил, хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөрт хамрагдаж буй бичил уурхай эрхлэгч 150 өрхөд 3 удаагийн сургалт зохион байгууллаа.

“Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль” болон Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоол, 2013 оны 20,144,311 дугаар тогтоолууд, 2016 оны 94 дүгээр тогтоолын дагуу 2017 онд ХХҮГ- тай шинээр гэрээ байгуулсан орон нутгийн “Нэвт” амралт, сувилалд 115, “Эвт урлал” амралт сувилалд 20 ахмад амруулсан. Орон нутгийн амралт, сувилалд нийт 180 гаруй ахмад амарч сувилуулаад байна. Улаанбаатар хотын дүүргүүдийн амралт сувилалд амрахаар 5 ахмад настан эрхийн бичиг авсан байна.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын аймгийн салбар комисс 07 дугаар сарын 05-ны өдөр хуралдаж хөгжлийн бэрхшээлтэй 18 хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрууллаа. Мөн комиссын гишүүдийн цагийн бүртгэл тайланг нэгтгэж төв комисст хүргүүллээ.

Ортопедийн тусгай хэрэгсэл авах хэрэгцээтэй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй үйлчилгээ авах эрх үүссэн 27 иргэнд ортопедийн туслах хэрэгсэл олгож, waic программд бүртгэлээ.

**Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс:** Тайлант сард нийт 192 ажил идэвхитэй хайгч иргэнийг шинээр бүртгэж, 783 иргэний мэдээллийг шинэчлэн, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд идэвхижүүлж 101 хүнийг ажилд зуучилсан.

07 дугаар сарын 25-ны байдлаар оны эхнээс өссөн дүнгээр: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд бүртгэлтэй ажил хайгч иргэд 1993 үүнээс эмэгтэй 1041, ажилгүй иргэн 1271 үүнээс эмэгтэй 710, шинэ ажлын байранд орсон иргэн 347 үүнээс эмэгтэй 125, ажлын байрны захиалгын тоо 783 байна. Ажил идэвхитэй хайгчдаас 714 иргэнийг ажлын байранд зуучлан оруулсан үүнээс 330 эмэгтэй байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээг нийт 248 иргэнд /өссөн дүнгээр/ үзүүлсэн байна. Тухайн сард ганцаарчилсан зөвлөгөөнд 44 иргэнийг хамруулснаас ажил хайгч 22, ажил олоход хүндрэлтэй иргэн 13, Ерөнхий боловсролын сургуулийн сурагч 2, Их дээд сургууль төгсөгч 4, ажилчин албан хаагч 1, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2 байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд бүлгийн зөвлөгөөг 2 ажил олгогчийн хүсэлтээр 144 ажилтан албан хаагчдад, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 457-р ангийн 35 хоригдолд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

**Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрийн хүрээнд:** “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас “Залуу малчдад тулгамдаж буй асуудал шийдвэрлэх арга зам” сэдвээр зохион байгуулж буй “Залуу малчдын чуулга уулзалт”-ыг газрын даргаар ахлуулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй баг 07 дугаар сарын 22-29-ний өдрүүдэд Манхан, Зэрэг, Дарви, Алтай, Булган сумдын багуудад зохион байгууллаа.

“Ажлын байрыг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээ хэрэгжиж, тариалсан ногооны арчилгааг хийж байна. Энэ хөтөлбөрт хамрагдсан иргэдийн амрах, байрлах ажлын байрны барилгыг барьж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөнгөлттэй зээлд төсөл бичсэн иргэдийг хамруулах явц үргэлжилж, энэ сард 2 ажил олгогчид 16.0 сая төгрөгний зээл олголоо.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төв:** Асруулагчдад стандартын дагуу өдөрт 4 удаа, 7 хоногт 15 нэр төрлийн хоол хүнсээр үйлчилж байна. Асруулагчдыг халуун усанд оруулж, хэвтрийн асруулагчдад өдөр бүр тогтмол мэргэжлийн асаргаа үйлчилгээ үзүүлж ажилладаг.

07 дугаар сард асруулагчдын хоол хүнсэнд 2750150 төгрөг, эм тарианд 78000 төгрөг тус тус зарцууллаа.

**Ахмадын сувилалын “цагаан уул” цогцолбор:** “Цагаан-Уул” ахмадын сувилалд 12 ахмад настан амарч сувилууллаа. Эдгээр 112 ор хоногтой амрагчдаас 896.000 төгрөгийн орлого төвлөрлүүлэн ажиллалаа. Амрагчид, ажиллагсдын тав тухтай орчинг хангах зорилгоор 340500 төгрөгөөр амрагчдын өрөө болон гал тогооны өрөө тасалгаа, коридорийн засварыг ажилчдын хүчээр хийж гүйцэтгэлээ.

**Эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр:**

Нийгмийн даатгалын системийн хэмжээнд 2017 оныг “Эерэг хандлага-Чанартай үйлчилгээ”-ний жил болгон зарласантай холбогдуулан, шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд биелүүлж, иргэд даатгуулагч, өндөр настан, ажил олгогчдод үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг хөнгөн шуурхай хүртээмжтэй хүргэх, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж сангийн орлогыг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Эрүүл мэнд нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны А/35 тоот тушаалаар Тахир дутуу, тэжээгчээ алдсан иргэдийн “Тэтгэврийг банкны хүүгүйгээр урьдчилан” олгож байгаа бөгөөд Жаргалант сумын нэг иргэн тэтгэврээ урьдчилан авсан байна.

**Бичиг хэрэг дотоод ажил:** Тус хэлтэст 31 албан бичиг хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан бөгөөд 39 албан бичиг тоотыг холбогдох газарт хүргүүлж, 6 өргөдөл гомдол хүлээн авч 4 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа явж байна. Даатгуулагч иргэдэд 627 архивын лавлагаа гаргаж хэлтсийн сарын ажлын тайлан, мэдээг холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлж, цаг үеийн асуудлыг хэлэлцэн тодорхой шийдвэрүүд гарган биелэлтүүдийг тухай бүрт нь тооцон ажиллаж байна.

**Сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:** Сайн дурын даатгалд 5258 даатгуулагчийн 642,5, 8627 даатгуулагчийн 343,1 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгалын орлого төвлөрүүлсэн байна. Өндөр насны тэтгэвэрт 7535 хүнд 2142008.6, тахир дутуугийн тэтгэвэрт 1748 хүнд 409442.7, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 862 хүнд 204132.3, цэргийн тэтгэвэрт 193 хүнд 100140.4, үйлдвэрийн ослын тэтгэвэрт 27 хүнд 876215,4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Тэтгэмжийн даатгалын сангаас: Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 696 даатгуулагчид 729052.7, ХЧТА-н тэтгэмжид 458 даатгуулагчид 46274.6, ажилгүйдлийн тэтгэмжид 193 даатгуулагчид 258068.1, 184 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 184.000.000 төгрөгийг тус тус олгож зарцуулсан.

ЭХМКомиссын ээлжит хурлыг 07 дугаар сард 2 удаа хийж нийтдээ 109 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааны асуудлыг хэлэлцэж, 72 иргэний актыг сунгаж, 5 иргэний актыг цуцалж ажилласны гадна 32 иргэний хугацааны актыг шинээр тогтоосон. Энэ сарын байдлаар мэдээллийн баазад 3195 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлтэй байна.

**Тав: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:**

**Байгаль орчин, аялал жуулчлалын талаар:**

**Удирдлага, зохион байгуулалт, дотоод ажлын талаар:** Байгууллагын дотоод хурлыг долоо хоног бүр тогтмол зохион байгуулж, хийж хэрэгжүүлж буй ажлууд, тулгамдсан асуудлуудаа ярилцан шийдвэрлэн ажиллаж байна.

Улсын баяр наадам болж байгаатай холбоотой байгаль орчны байгууллагуудын баярын үеэр ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг гаргаж, холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.

**Ан айудан, тусгай хамгаалалттай газрын талаар:** Де Нэйчэ консерванси олон улсын байгууллагаас хийж буй экологийн бүс нутгийн үнэлгээгээр тус аймагт экологийн онцгой ач холбогдолтой зайлшгүй хамгаалалтад авах шаардлагатай газруудаас Мөнххайрхан сум Иргэдийн төлөөлөгчдын хурлын 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 4/07 тоот тогтоолоор “Хүрэлдэйн-Ханхайн нурууг орон нутгийн тусгай хамгаалалтанд бүртгүүллээ.

Мөн Ховд гол-Сартагтайн гууг орон нутгийн хамгаалалтад авахаар Эрдэнэбүрэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04 тоот тогтоол, Мянгад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 04 тоот тогтоолуудыг гаргаж Ашигт малтмалын кадастрын хэлтэст хүргүүлсэн боловч хариу хараахан ирээгүй байна.

**Аялал жуулчлалын талаар:** Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Гурван Сэнхэр төвтэй таван од” аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ гэж заасан.

Ховд аймаг нь монголдоо төдийгүй дэлхийд алдартай Гурван Сэнхэрийн агуйгаа аялал жуулчлалын зорих газар болгон тохижуулж, түүнээс салаалсан 5 чиглэлийн аялалын маршрутыг бий болгон аялал жуулчлалыг хөгжүүлэхээр зорин ажиллаж байгаатай холбоотой хөтөлбөр боловсруулах хэлэлцүүлгийг зохион байгуулсан ба хэлэлцүүлгээр гадны шинжээчдийн багийг ажиллуулах шийдвэр гаргасан. Шинжээчдийн хийсэн “Гурван Сэнхэр төвтэй таван од” аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн эхний боловсруулалтанд санал зөвлөмж өгсөн.

**Орчны бохирдлын талаар:** Ардын хувсгалын 96 жилийн ойн баярын өмнө хоггүй цэвэр сайхан орчин бүрдүүлэхээр аймгийн Засаг даргын орлогчийн 07 дугаар сарын 05-ны өдрийн 1/1680 тоот албан бичиг гаргуулан бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг 7 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулав.

“Бүх нийтийн цэвэрлэгээн”-д аймгийн Засаг даргын Тамгын газар, Барилга, хот байгуулалтын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Эрүүл мэндийн төв, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Хотын захирагчийн албаны 22 ажилтан, байгаль орчны чиглэлийн байгууллагууд оролцов. Энэхүү ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэж, нийт 100 орчим ажилчид оролцож, 2 тэвш буюу 3 тонн хог хаягдлыг хогийн төвлөрсөн цэгт хүргэлээ.

**Ойн талаар:** Байгууллагын мод үржүүлгийн талбайн хүлэмж болон ил талбайн зэрлэг түүх, таримал ойг хортон шавьжнаас урьдчилан сэргийлэх зорилгоор хор цацаж, аж ахуй нэгж, иргэд, байгууллагадхортноос урьдчилан сэргийлэх, хор хэрэглэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Нэн ховор, ховордсон, ашигт ургамлыг тарималжуулах зорилгоор Жаргалантын хүрэн өндрийн амнаас Алтан гагнуур түүж байгууллагын хүлэмжинд тарьж туршиж байна.

**Хяналт шалгалтын талаар:** Үенч, Бодонч, Булган голын сав газар сумын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нар ажлын хэсэг байгуулан Булган сумын Доод нарийны гол гэдэг газар Улаанбаатар хотоос ирсэн “Пүрэвдаш” ХХК нь 6 гэр барин машин техник байрлуулж, 3 том нүх ухсан байдалтай байсан ба алт угааж, олборлох үйл ажиллагаа эхлээгүй байсан тул үйл ажиллагааг зогсоож, нүхийг булуулж, гэр болон машин техникийг ачуулан явуулж газар дээр нь хяналт тавин ажиллалаа.

Мянгад сумын байгаль хамгаалагчид Чацарганат багийн нутаг дэвсгэрт “Алтны ам” гэдэг газар “Хаан буурынхан” ХХК, Баянбулаг багийн Тавхайн гол гэдэг газарт

“ММНС” ХХК-иуд ямар нэгэн зөвшөөрөлгүй хайгуулын үйл ажиллагаа явуулж байсныг үйл ажиллагааг нь таслан зогсоож буулгасан.

### **Хөдөө аж ахуй**

**Мал аж ахуйн өвөлжилт,** Хадлан тэжээл бэлтгэх тухай Засгийн газрын тогтоол шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг даргын албан даалгавар гаргуулж, хэрэгжилтийг хангуулж байна. Энэ жил манай аймгийн ихэнх нутгаар гандуу байгаатай холбоотойгоор аймгийн УЦУОШ-ний газрын мэдээ авч сумдад цаг үеийн ажлыг эрчимжүүлэх чиглэл өгч ажиллалаа.

Мал эмнэлгийн холбогдолтой болон лабораторийн шинжилгээний хагас жилийн мэдээ тайлан, аймгийн Засаг дарга, сайдтай байгуулсан гэрээ, хөтөлбөрийн биелэлтүүдийг гаргаж холбогдох газар хүргүүлээд байна.

Алтай, Булган, Үенч, Мөст, Мөнххайрхан сумдын Засаг дарга, МЭҮТ-ийн дарга нарт Шүлхий өвчний дархлаажуулалтын арга хэмжээнд хамрагдах малын судалгаа гаргаж ирүүлэх тухай албан тоот гарган хүргүүлэв.

Алтай, Булган, Үенч, Зэрэг, Дарви, Мөст сумдын хээлтүүлэгч малд бруцеллёзын шинжилгээ хийх ажлын удирдамж гарган зардлыг төлөвлөн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлэв.

Лабораторийн 2017 оны шинжилгээний зардлын задаргаа, 2018 оны шинжилгээний зардлын төсөв хийж батлуулав.

#### **Мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар:**

Энэ онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 153.6 мянган толгой бод, 291.6 мянган толгой бог нийт 1445.2 мянган толгой малыг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахаас эхний хагас жилд 1.329.6 мянган толгой мал буюу 92.1 хувьтай хийгдэж байна.

Энэ оны эхний 6 сарын байдлаар 11 сумын 22 багт Цусан халдварт, Колибактериоз, Галзуу, Сахуу, Шөвөг яр, Сохор догол, Цахлай зэрэг 7 төрлийн халдварт өвчин 33 голомтонд дэгдэж, 110 мал өвчилж, 22 мал хорогдож, 86 мал эдгэрч 2 малыг устгасан байна.

**Лабораторийн шинжилгээ ариутгал халдваргүйтгэл:** “Мон Вет Мед” компаниас тендерээр тус лабораторид нийлүүлсэн 9,5 сая төгрөгийн үнэ бүхий оношлуур, урвалж бодис, лабораторийн хэрэглэгдхүүнийг хүлээн авч орлого, зарлагын баримтыг бүрдүүлэн хүргүүлээ.

Шүлхий, бог малын мялзан өвчнийг тандах шинжилгээг Алтай, Булган, Үенч, Зэрэг, Мянгад сумдын нийт 496 малын дээжинд ийлдсийн шинжилгээ хийхэд мялзан өвчний шинжилгээгээр 325 дээж, шүлхий өвчний шинжилгээгээр 9 мал эерэг дүнтэй гарав.

Лабораторийн шинжлэгч эмч нар Алтай, Булган, Үенч, Зэрэг, Дарви, Мөст сумдын хээлтүүлэгч малд бруцеллёз, ям, сүрьеэ, цагирган урвалын шинжилгээ хийж байна.

Увс аймгийн мал эмнэлгийн лабораторийн эмч нар ирж манай эмч нартай хамтран бог малын мялзан, шүлхий өвчний шинжилгээг нийт 780 дээжинд хийв.

Хан орд хүнсний захад худалдаалагдаж байгаа 4440 кг махны 120 дээж, 1180 л сүүний 66 дээж, арьс 700, ноолуур 1000, өлөн 1000 ш гогцоонд мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээ хийж, 350 м/кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн байна.

**Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, газар тариалангийн үйл ажиллагааны талаар:** Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн дунд “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх” хөтөлбөрийн төслийг танилцуулах

хэлэлцүүлгийг аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгуулаад байна.

Малчдын өрхийн бүртгэлийн дэвтэрт хоршооны тухай ойлголт болон хоршооны гишүүн малчин өрхийн хөтөлбөл зохих бүртгэлийг тусгаж өглөө.

Сум хөгжүүлэх сангийн 2017 оны эхний хагас жилийн мэдээг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргаж яаманд хүргүүлээд байна. Уг мэдээгээр нийт 6.4 тэр бум төгрөгийн 1152 төсөл хэрэгжиж байна. Үүнээс эхний хагас жилд 92 төсөлд 370.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож 48 ажлын байр шинээр бий болж, 50 ажлын байр хадгалагдсан байна.

**Зам тээврийн чиглэлээр:** Аймгийн замын сангийн 334,9 сая төгрөгөөр хийгдэх төсөл арга хэмжээний дагуу худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулав. Үүнд:

Жаргалант суманд 1,5 метр өргөнтэй, 3 км урт бүхий явган хүний замын ажлыг “Зол дайчин” ХХК гүйцэтгэж байна.

Тавтын хөтлөөр Мөнххайрхан сумын чиглэлд 65 км ердийн хөрсөн замд засвар шинэчлэлтийн ажлыг “Ховд АЗЗА” ТӨХК гүйцэтгэж, ашиглалтад өгөхөд бэлэн болоод байна.

Жаргалант сум доторх хатуу хучилттай авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг орон нутгийн “Түм дэлгэрэх” ХХК гүйцэтгэгчээр шалгарч ажлаа эхлэхэд бэлэн болоод байна.

Жаргалант сум доторх 10 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг, Чандмань сумын чиглэлд 62 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ боловсруулах ажлыг “Гео зураглал” ХХК гүйцэтгэгчээр шалгарч, гэрээ хийхэд бэлэн болоод байна.

**Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:** Газрын тухай зөрчил маргааныг арилгах зорилгоор зарим иргэдийн зөрчилтэй хашааг албадан буулгах, Рашаант багийн Шаврын тохойд зөвшөөрөлгүй замын хар буулган хашаа татахдаа ашиглана гэж байсан иргэдийн буулгасан замын харыг буцаан ачуулах, Буянт голын эрэг орчмын зөвшөөрөлгүй татсан тор, хашааны судалгааг гарган судалгаагаар илэрсэн зөрчлийг хууль тогтоомжийн хүрээнд арилгах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг 07 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Ховд, Булган, Буянт, Чандмань, Манхан сумдад ажиллалаа.

Газрын биржийн программ дээр 41 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барьцаа үнийн мэдээ 25-ыг бүртгэсэн. Газрын төлбөрийн хувьд 2017 онд 123960,0 төвлөрөхөөс 7сарын 31-ний байдлаар 80514,0 төгрөг буюу газрын нийт төлбөрийн 65% нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас төвлөрөөд байна.

БМ-19 маягт болон орон сууцны эрэлт нийлүүлэлтийн судалгаанд баяжилт хийлээ. ХОХБТХ-т аймгийн НААҮ-ний бүртгэл ирүүлсэн маягтын дагуу гаргаж [tumee\\_arch@yahoo.com](mailto:tumee_arch@yahoo.com) хаягаар илгээлээ.

07 дугаар сарын 09-ний өдөр аймгийн Засаг дарга Д.Галсандондог, орлогч дарга Ш.Батсүх, ГХБХБГ-ын дарга Э.Дөлбадрал, мэргэжилтэн Д.Барсболд, Д.Тогтохбаяр, Б.Төгөлдөр нар Магсаржав багийн иргэн н.Эрдэнэчимэг нарын иргэдийн гаргасан гомдол мэдээллийн дагуу газар дээр нь очиж үзэн оршин суугчидтай уулзан асуудлыг шийдвэрлэхээр харилцан ярилцаж тохиролцов.

БХТ-д [osnaax\\_agentlag@yahoo.com](mailto:osnaax_agentlag@yahoo.com) хаягаар орон сууцны борлуулалт, ашиглалтад орсон орон сууцны мэдээг илгээлээ.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч С.Чанцал, БХБХ-ийн дарга З.Өмиртай, мэргэжилтэн Д.Барсболд, Д.Тогтохбаяр, нарын хамт аймгийн төвд баригдаж буй зарим барилгууд дээр хяналт хийлээ. Үүнд: Турлиахт, Тэгш таван өргөө, Вива зоне,

Хатантүнгэл, Баруун жонон, Динатос, Ховд Юхо, Богоч констракшн, Гэрэл гэгээ, Дарви өргөө, БАМИ зэрэг компаниудын барьж буй орон сууцны барилга, Тулгат багана ХХК-ийн гүйцэтгэж буй цэцэрлэгийн барилгын засварын ажлуудад тус тус хяналт хийж зохих шаардлага, зөвлөмжийг өгч ажиллалаа.

“ГЦЦЭ” ХХК-ийн барьж буй зочид буудлын барилгад хяналт хийлээ. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын лабораторид өгсөн материалынхаа шинжилгээний хариугаа авсан, материалаа дахин шинжлүүлнэ гэсэн тайлбар өгөв. Барилга баригдаж, дотоод шавардлагын ажил хийгдэж байна.

Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид 6 байгууллагаас 3 төрлийн материал ирүүлснээс 7 нэр төрлийн сорьцонд шинжилгээ хийсэн байна. Үүнд: “Алтайн Газрын хүч” ХХК, “Баруун Жонон” ХХК, Баян-Өлгий аймгийн “Тэнэгэр алтан тоосго” ХХК, “Каусар” ХХК, “Ховд Шинэ Асар” ХХК, иргэн Д.Цэнгэл нараас сорьцоо ирүүлсэн байна. Үүнд: Бетон сорьцын 3, тоосгоны 2, хөнгөн блокны 2 сорьц тус тус ирсэн байна.

### **Зургаа: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтыг 07 дугаар сарын 19-ний өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд болон сум, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, бодлогын баримт бичиг, эрх зүйн актуудын биелэлт хариуцсан 60 гаруй хүн хамрагдав.

Сургалтанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Нийгмийн бодлогын хэлтсийн дарга нар оролцов. Сургалтын үеэр Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн боловсруулсан аймагт мөрдөж ажиллах “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захиргааны болон төсвийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын төслийг танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулж, “Сертификат” гардуулав.

Хэлэлцүүлгийн үеэр хэлтсийн дарга, сум, байгууллагын мэргэжилтнүүдээс гарсан саналыг “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захиргааны болон төсвийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын төсөлд тусган, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр болоод байна.

07 дугаар сарын байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 3, Засгийн газрын 30 тогтоол, 7 хуралдааны тэмдэглэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3, Тэргүүлэгчдийн 73 тогтоол хүлээн авч аймгийн удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

### **Долоо: Сумдын мэдээлэл:**

**Жаргалант сум: Нийгмийн бодлогын чиглэлээр:** Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зорилтот бүлгийн 6 сартайгаас 5 насны хоол тэжээлийн хурц болон архаг дутагдлаас үүдэлтэй рахит, тураал, цус багадалт зэрэг суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэн эрүүлжүүлэх “Зуны сувилал-

эмийн бус эмчилгээ ба чийрэгжүүлэлт ”-ийн үйл ажиллагааг хуваарийн зохион байгуулан ажиллаж байна.

Ганданпунцагчойлон хийдийн дэмжлэгтэйгээр амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой зорилтот бүлгийн 36 өрхөд 4320000 төгрөг /дөрвөн сая гурван зуун хорин мянган/-ийн хоол хүнс, хүүхдүүдийн хичээлийн хэрэгслийг олголоо.

**Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр:** Мал эмнэлэг үржлийн нэгжүүдтэй хамтран тус суманд өсгөн үржүүлж байгаа 250 толгой ухна, 200 толгой хуцнаас цусны дээж авч аймгийн ХХААХУ-ийн газарт хүргүүлээд байна.

Тус сумын харъяат малчин болон мал бүхий 42 өрхүүдээр явж малын гоц халдварт мялзан, цэцэг өвчний тандалт судалгааг хийгээд байна.

**Газар зохион байгуулалт дэд бүтцийн чиглэлээр:** Жаргалант сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 3 байршилд төсөл сонгон шалгаруулалт явагдаж нийт 29 га газар зарлагдсанаас 6.5 га газрыг эзэмшүүлэхээр боллоо.

**Байгаль орчны чиглэлээр:** 07 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Жаргалант сумын Рашаант багийн нутаг Жишиг хороололд зөвшөөрөлгүй алт угааж байна гэсэн мэдээллийн дагуу Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон байгаль орчны байцаагч нар холбогдох хуулийн байгууллагатай хамтран үзлэг шалгалтыг хийж тухайн иргэний үйл ажиллагаа явуулж байсан газрыг лацдаж хууль бус үйлдлийг таслан зогсоов.

Жаргалант сумын ИТХ-ын 2017 оны 82 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан “Буянт голын сав дагуу газарт дагаж мөрдөх журам”-ыг хэрэгжүүлэн, голын сав дагуу газарт автомашин угаах, хориглосон газарт айл буухыг зогсоох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, ойр орчмын хог хаягдлыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас цалинжуулж байгаа 10 ажилтнаар цэвэрлүүлэн ажиллаж байна.

Усны тухай хуулийн 7.3 дахь заалтын дагуу усны тоо бүртгэлийг Хар нуур Ховд голын сав газрын захиргааны мэргэжилтнүүдтэй хамтран Жаргалант сумын 12 багийн худаг уст цэгүүдийг шинэчлэн бүртгэлээ.

**Алтай сум:** Их Монгол улс байгуулагдсаны 811 Ардын хувьсгалын 96 жилийн ойн баяр наадмыг аймгийн Засаг даргын захирамж болон сумын Засаг даргын захирамжийг удирдлага болгон 07 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгуулж, 128 хүчит бөх барилдаж, сумын заан Н.Баяр-Эрдэнэ түрүүлж, сумын начин Б.Батболд үзүүлж сумын харцага цолны болзол хангалаа. 7 насны 280 морь уралдаж, унаач 64 хүүхдийг даатгалд хамруулж ажилласан.

07 дугаар 16-18-ны өдрүүдэд Барлаг, Алтангадас, Бодонч багуудын ИНХ-ын хурлыг зохион байгуулж, Малжуулах төсөл, уул уурхайн чиглэлээр нөхөн сэргээх асуудал, бусад асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргаж ажиллалаа.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус хуралдаан 07 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, 2017 оны төсвийн байгууллагуудын эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, Орон нутгийн тусгай хэрэгцээнд ашиглах газрын нэр хэлэлцэн батлах, Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлын тайлан цаашдын зорилт, татварын эхний хагас жилийн биелэлт, Нөхөн сэргээлт зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж холбогдох тогтоол гаргалаа.

Сумын хэмжээнд 435 хуц, ухнаас цусны дээж, 200 үнээ, 300 ямааны сүүнээс дээж, нийт 935 малын цус, сүүний дээж авч аймгийн ХХААГ-ын лабориторт шинжилгээнд явууллаа.

Хөдөлмөр нийгмийн хамгаалалын ерөнхий газрын дарга Б.Нямдаваа, Монгол улсын гавъяат малчин н.Эрдэнэчулуун, аймгийн ХХҮГ-ын дарга Л.Билэгдэмбэрэл нараар ахлуулсан ажлын хэсэг 07 сарын 25-нд Ангиртын голд Алтай сум, Цэцэг сумдын залуу малчидтай уулзалт зохион байгуулж, нийт 2 сумын 350 залуу малчид оролцлоо.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу 07 сарын 26-нд Ангиртын голд “Шилмэл мал”-ын үзэсгэлэн худалдаа зохион байгуулав. Шилмэл малын үзэсгэлэн худалдаанд 3 багийн 45 мал оролцож ашиг шимийн



үзүүлэлтээрээ шалгарсан 15 малд, гойд ашиг шимт малын диплом олгож, алт, мөнгө, хүрэл медаль олгож, мөнгөн шагналаар шагнав.

**Булган сум:** Сумын иргэдийн Төлөөлөгчдын хурлыг 07 сарын 19-ний өдөр зохион байгуулж, 90%-ийн ирцтэйгээр хуралдлаа. Хурлаар сумын Засаг даргын ажлын тайлан, сумын газар зохион байгуулалт, Доод нарийнд нөхөн сэргээлт хийхтэй холбоотой асуудлуудыг авч хэлэлцсэн.

Сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, үндэсний бөхийн барилдаанд хүчит 64 бөх барилдаж Б.Ганзориг түрүүлэн сумын заан цолны болзол хангаж, сумын заан Д.Баяболат үзүүрлэв.

Үндэсний сурын харваанд 16 харваач цэц мэргэнээ сорьсоноос сумын мэргэн Б.Хайртмөнх 1 дүгээр байр, Б.Отгонбаатар 2 дугаар байр эзэлж гарамгай харваач цол, 3 дугаар байранд Ш.Алтангэрэл, 4 дүгээр байранд н.Хашбаатар Баян-Өлгий аймгийн Булган сумын иргэн, 5 дугаар байранд Б.Атарбаян нар тус тус шалгарсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 3/03 тоот тогтоолоор аймгийн газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөнд “Элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газрын байршил, хэмжээ”-г баталсаны дотор тус суманд Байтаг багийн Геологийн цагаан толгой, Их улаан уул – 9 га, Байтаг багийн Цөмөрдөг толгой орчимд – 3 га, Алагтолгой багийн Мянгатын аманд – 0.4 га, Баянсудал багийн Доод нарийний аманд – 5 га, Баянсудал багийн Тэмээний хондод – 4 га, Бүрэнхайрхан баг, сумын төвд хогтой 6.55 га 6 газрыг нөхөн сэргээлтэнд хамруулахаар шийдвэрлэсэн.

Баянсудал багийн Доод нарийнд нөхөн сэргээлтийг “Пүрэвдаш ХХК” хийж гүйцэтгэх байсан боловч хууль бус агаар алт олборлох гэж байна гэсэн иргэдийн эсэргүйцэлтэй тулгарч үүнтэй холбоотой сумын Засаг даргын А/69 тоот захирамжаар сумын Засаг дарга, “Пүрэвдаш ХХК”-ны хооронд байгуулсан 2017 оны хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийх ажлын 01 тоот гэрээг 07 сарын 19-ний өдрөөр цуцалсан. Үүнтэй холбогдуулан Булган голын хамгаалалтын бүсэд хууль бус аргаар алт олборлож, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаад хяналт тавихаар БОАЖЯ-наас томилогдсон ажлын хэсэг, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газартай хамтран ажиллаж, үйл ажиллагаатай газар дээр нь танилцлаа.

Нэгдсэн эмнэлэгийн барилгын ажил хэвийн явагдаж байна. Минжит Булган цогцолбор сургуулийн засвар дээвэр, халаалтыг аймгийн “Жаргалант луу” ХХК 119 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэж байна.

**Буянт сум: Иргэний бүртгэл, өргөдөл гомдол:** Сумын Засаг даргын Тамгын газар нь 07 дугаар сард иргэдээс бичгээр 4 өргөдөл хүлээн авч 4 өргөдөл шийдвэрлэсэн байна. Иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээг шинээр төрсөн хүүхэд 39 /эрэгтэй 25, эмэгтэй 14/, гэрлэлт бүртгэл 17, нас баралт 14, /эрэгтэй 10, эмэгтэй 4/, иргэний шинэчилсэн бүртгэл 81, анх удаа иргэний үнэмлэх авч байгаа 16 настай 36, 25 насны сунгалт 21, 45 насны сунгалт 24, эцэг тогтоолтын бүртгэл 5, эд хөрөнгийн анхны бүртгэл 25, нийт 181 иргэнд үзүүллээ.

**Эдийн засаг, төсөв, шилэн дансны үйлчилгээний чиглэлээр:** Төсөв санхүүгийн чиглэлээр: Орон нутгийн төсвийн орлого 24.9 сая төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэл нь 21.2 сая төгрөг 85.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант сард улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 126222.1 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 100% авсан. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагууд төлөвлөгөөний дагуу өөрийн байгууллагын санхүүжилтийг 100% авсан байна. Сум хөгжүүлэх сангийн дансанд үндсэн зээл, хүүгийн төлбөрт 13.5 сая

төгрөг төвлөрүүлээ. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зарлага санхүүжилтийн 7 дугаар сарын мэдээг ЗДТГ-ын ил тод байдлын мэдээллийн самбараар 1, сумын вэб сайтад 1 удаа, төсөвт 5 байгууллагад тус тус байршууллаа. 5 төрлийн мэдээ тайланг батлагдсан маягтын дагуу хугацаанд нь нэгтгэн гаргаж аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлээ.

**Спорт, соёл урлагийн чиглэлээр:** Сумын Соёлын төвд спортын 4 арга хэмжээ зохион байгуулж 320, хурал, уулзалт, сургалтын 2 арга хэмжээ зохион байгуулж 230, урлаг уран сайхны арга хэмжээ зохион байгуулж 50, нийт давхардсан тоогоор 700 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлээ. Соёлын төв 200.0 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэйгээс 212.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлээ. Сумын Соёлын төвийн номын сангаас 5 төрлийн номоор 15 иргэнд хүрч үйлчиллээ.

**Эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр:** Сумын Эрүүл мэндийн төв нь 309 иргэнд үзлэг хийснээс амбулаторын үзлэг 121, урьдчилан сэргийлэх үзлэг 72, гэрийн идэвхитэй эргэлт 25, идэвхитэй хяналт 39 удаа хийлээ. Нийт дуудлага 26 ирснээс алсын дуудлагад 15, ойрын дуудлагад 11 удаа явж эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламжийг цаг алдалгүй хүргэлээ. Энэ сард товлолын вакцинд 43 хүүхэд хамруулж, 0-3 сартай жирэмсэн 7 эхийг шинээр хяналтанд авлаа. Сумын эмнэлэгт 24 өвчтөнд анхан шатны маягт хөтлөн хүлээн авч, 36 нэр төрлийн 298,0 мянган төгрөгийн эм тариагаар үйлчиллээ. “Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт сургалтыг 16 хэвтэн эмчлүүлэгсдэд болон ард иргэдэд зохион байгуулсан. Мөн өрхийн 4 эмч 10 өрхийн 17 иргэдэд Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийж, гарын авлага 38 ширхэгийг тарааж өгсөн. Сумын ЭМТөв дотоодын сургалтыг 1 удаа зохион байгуулж, нийт 13 эмч, ажиллагсад хамрагдлаа.

**Нийгмийн хамгааллын чиглэлээр:** Нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлтөнд хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн материалыг хүлээн авч цаг хугацаанд нь программд оруулан ажиллаж байна. Ахмад настны нэг удаагийн тэтгэмж тусламж болох шүд хийлгэсний үнийн хөнгөлөлтийг 7 иргэнд 700.0, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд хийлгэсэн шүдний үнэ 120.0, УБ хот явж эмчилгээ шинжилгээ хийлгэсний унааны нэг талын зардлын хөнгөлөлтийг 8 иргэнд 1252100 төгрөгийг тус тус олгосон байна. Хөдөлмөрийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг нийтэд сурталчлан ажиллаж байгаа ба ажилгүй иргэдийн судалгаа шинэ ажлын байрны сарын мэдээг сар бүр тогтмол өгч ажиллаж байна. Хүнс тэжээл хөтөлбөрт 8 өрх хамрагдан хүнсний дэмжлэг авч байгаа ба сардаа 552000 төгрөгийн санхүүжилт хийгдэж байна.

**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Сумын хэмжээнд 13 иргэнд холбогдох хуулийн дагуу хууль зүйн зөвлөгөө өглөө. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нар хэв журам сахиулахаар өдөр бүр шөнийн эргүүлийг 21 удаа 172 цаг гарч, ахуйн дуудлагад 10 удаа, ахуйн шинжтэй 5 дуудлагад очиж, биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон 5 иргэнийг түр саатуулан ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, ар гэртээ агсан тавьсан 3 иргэнийг эрүүлжүүлэх, баривчлах байранд хүргүүлсэн. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг хүнсний дэлгүүрүүдэд давхардсан тоогоор 16 удаа хяналт шалгалт хийж ажиллалаа.

**Дарви сум:** Сумын баяр наадмыг 7 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлээ. Засаг даргын Тамгын газрын урсгал засвар, Хүүхдийн цэцэрлэгийн дээврийг шинээр хийсэн. Уг ажлыг Ховд “Сутайн цамхаг” ХХК гүйцэтгэв.

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны засварыг эхлүүлсэн.  
“Буянтын боргио” ХХК гүйцэтгэгчээр ажиллаж байна.  
Мөнгөн аяга багийн Тахилт булгийн эхийг торлон хамгаалав.

**Дөргөн сум: Төрийн удирдлагын чиглэлээр** :Сумын ИТХ-ын ээлжит 3 дугаар хуралдаан 07 дугаар сарын 03-ны өдөр 71.4 хувийн ирцтэйгээр хуралдаж, ИТХ-ын 2017 оны хагас жилийн ажлын тайлан, Төлөөлөгчдийг чадавхжуулах дэд хөтөлбөр, сумын Засаг даргын 2017 оны нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлийн хагас жилийн биелэлт, 2017 оны төсвийн тодотгол, сум хөгжүүлэх сангийн зээл олгох дээд хэмжээг тогтоох, Монгол улсын алдарт уяач Н.Батбаярын цолны баяр зохион байгуулах тов тогтоох зэрэг асуудлуудыг хэлэлцэн баталж, шийдвэр гаргалаа.

Тулгар төрийн 2226, Их Монгол улсын 811, Ардын хувьсгалын 96 жилийн ойн баяр наадмыг 07 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд сумын төвд зохион байгуулж, наадамчин олноо цэнгүүллээ.

Хурдан морьдын уралдаанд 33 унаач хүүхдийг бүртгэж, гэнэтийн ослын даатгалд хамруулж, эцэг эх, асран хамгаалагчаас нь албан ёсны зөвшөөрөл олгосон бичиг үйлдүүлж, зориулалтын малгай, хувцсаар бүрэн хангаж, 6 насны морьдын уралдааныг хууль журмынхаа дагуу зохион байгуулсанаар мориноосоо унаж бэртсэн хүүхэд байхгүй амжилттай болсон.

2018 оны төсвийн төслийг байгууллага тус бүрээр нь төлөвлөн гаргаж, аймгийн төрийн сан болон боловсрол, соёлын газар, эрүүл мэндийн газарт тушаасан.

7 дугаар сарын 17-нд Аргалант багийн ИНХ-ын ээлжит хуралдааныг гүүрийн амын багийн төв дээр хийж шилмэл хээлтүүлэгчийн суурь бий болгох, улсын алдарт уяач Н.Батбаярын цолны баяр хийх, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, Хөх эргийн аарагт газрын нөхөн сэргээлт хийх зэрэг асуудлыг хэлэлцэж, шийдвэрт хүрсэн.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр** : Бог малын мялзан өвчинөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хөдөөгийн багуудын төл малыг вакцинжуулахаар судалгааг гаргаж Хүнс хөдөө аж ахуйн газар хүргүүлсэн.

“Алтайн шилмэл сүрэг” мал эмнэлэг, “Агваш арал” мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдийн малын эмч нар хөдөөгийн багуудын ирсэн малчдын дуудлага бүрт очиж үйлчилгээ үзүүлж байна.

**Татварын чиглэлээр** :Эхний хагас жилийн байдлаар Орон нутгийн төсөвт нийт 10594000 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 27345579.65 төгрөг төвлөрүүлж 258.1, аймгийн төвлөрсөн төсөвт нийт 85514400 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 111338895.2 төгрөг төвлөрүүлж 130.2, улсын төвлөрсөн төсөвт нийт 58087200 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 63601173,78 төгрөг төвлөрүүлж 109.5, нийт дүнгээр төсөвт 154195600 төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 202285648.6 төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 131.2 хувиар тус тус биелүүлсэн байна.

2017 оны 2 дугаар улирлын татвар болон санхүүгийн тайланг аж ахуйн нэгжүүдээр бүрэн тушаалаа.

**Нийгмийн даатгалын чиглэлээр**: 348 тэтгэвэр авагчдад 92242.600 мянган төгрөгийн санхүүжилтээр өндөр насны тэтгэвэр авагч 243, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 35, тахир дутуугийн тэтгэвэр авагч 70 иргэний тэтгэвэрийг бүрэн тавьж олгосон байна. Шинээр энэ сард 5 иргэнд өндөр настны болон тахир дутуугийн, тэжээгчээ алдсан тэтгэвэр тогтоосон.

Сайн дурын даатгалд нийтдээ 56 даатгуулагчийн 4740.000, төсвийн байгууллага болон ААН-үүдээс нийтдээ 9138.000 төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн. Энэ сард 5 даатгуулагч шинээр сайн дурын даатгалын гэрээ байгуулсан. Эрүүл мэндийн даатгалд 51 хүний 1695.000 төгрөгийн орлого оруулсан.

Тэтгэмжийн даатгалын сангаас 3 эхэд 1955000 төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж, 1 өндөр насны тэтгэвэр авагчид 1000.000 төгрөгний оршуулгын тэтгэмж, 1 хүнд хөдөлмөрийн чадвар алдагчийн тэтгэмжид 675000 төгрөгийг олгосон.

**Улсын бүртгэлийн чиглэлээр:** 07 дугаар сард 8 төрлийн бүртгэлээр төрөлт 12, нас баралт 1, үрчлэлт 2, шилжиж ирсэн 6, шилжиж явсан 6 иргэний үнэмлэх шинээр захиалсан болон 25, 45 насны сунгалт хийлгэсэн 13, цахим үнэмлэх дахин захиалсан 4 иргэний бүртгэлийг тус тус хийж, 20 хүнд иргэний цахим үнэмлэх олгосон

**Байгаль хамгаалах чиглэлээр:** 7 дугаар сарын 08-ны өдөр төсвийн 5 байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэд сумын төвийн эргэн тойронд их цэвэрлэгээ хийж, хогийг хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлж устгасан. Нийтдээ давхардсан тоогоор 380 гаруй хүн оролцлоо. Мөн гол нуураа хамгаалах зорилгоор татсан торонд хуримтлагдсан хогийг цэвэрлэж, унасан торыг нь сэлбэн засварласан.

**Соёлын ажлын талаар :** Ардын хувьсгалын 96 жилийн ойн баярт зориулсан үндэсний телевизийн 4 бэрх нэвтрүүлэгт сумаас 6 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож 2-р байр эзэлсэн.

Аймагт зохион байгуулагдсан улсын Бий биелэгээний анхдугаар наадамд хүүхэд, насанд хүрэгчдийн ангилалд хамтлаг, гоцлол төрлөөр 16 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, хүүхдийн хамтлаг тусгай байр эзэлж, Г.Алтанзаяа сод биелээч Норолхоон нэрэмжит шагналаар шагнагдлаа. Мөн соёлын төвийн эрхлэгч С.Дэжид Улсын бий биелэгээний наадмын хөтлөгчөөр ажилласан.

Тува улсад зохион байгуулагдах олон улсын хөөмийн наадамд сумаас оролцох 2 хүний материалыг бүрдүүлэн аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. Ажлын хэсэг байгуулагдан соёлын төвийн хөрөнгөд тооллого хийсэн.

**Эрүүл мэндийн төвийн ажлын талаар :** Аймгийн Эрүүл мэндийн газраас дэмжлэгт хяналт, шинжилгээ үнэлгээний шалгалт ирж эмч, мэргэжилтнүүдийн ажилтай нэг бүрчлэн танилцан, цаашид ажиллах арга зүйн зөвлөмж өгснийг ажилдаа тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Улсын баяр наадмын үеэр ард иргэдийн дунд хоолны хордлого, наршилт, осол гэмтэл, артерийн даралт ихсэх явдал ихээхэн тохиолдог тул урьдчилан сэргийлэх зөвлөмж бэлтгэн иргэдэд тарааж, сэрэмжлүүлэг зарыг мэдээллийн самбаруудад байршуулан ажилласан.

“Элэг бүтэн монгол” аяны хүрээнд 40-65 насны 325 иргэдэд элэгний В,С вирусын шинжилгээ хийж, В -тэй 49, С –тэй 52, ВС –тэй 2 хүн илэрснээс 45 хүнийг аймагт В,С вирусын идэвхжилийг тодорхойлох шинжилгээнд хамруулав.

**Дуут сум: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл:** Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 07 дугаар сарын 18-нд ИТХ-ын ээлжит 3 дугаар хуралдаанаа хийж, 6 асуудал хэлэлцэн 6 тогтоол гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Сумын ИТХ-д дээд газраас энэ сард хугацаатай бичиг 2 ирж, 1 бичгийг хугацаанд нь хариуг нь хүргүүлж, 1 бичгийн хариу хүлээгдэж байна.

**ЗДТГ-ын үйл ажиллагааны мэдээлэл:** Сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-нд зохион байгуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт болох нийт 4 сая төгрөгийн санхүүжилтээр баяр наадмаа тэмдэглэн өнгөрүүлсэн.

2017 оны 07 дугаар сарын байдлаар татварын орлогын төлөвлөгөө 11.200.0 төгрөг төлөвлөгдсөнөөс 18.945.0 төгрөг орж 154 хувийн биелэлттэй байна.

Иргэний бүртгэлийн мэдээллээр 7 дугаар сард төрөлт 1, гэрлэлт 1, шилжин явсан 6, шилжин ирсэн 1, иргэний үнэмлэх захиалсан 2, иргэний үнэмлэх олгосон 6 иргэн байна.

Сумын Засаг даргын Тамгын газарт нийт 23 бичиг ирснээс хугацаатай 10 бичиг байна. Үүнээс хугацаандаа явсан 4, хугацаа болоогүй 6 бичиг байна.

“Дуут царцаа” хоршооны 6900 га талбайд царцааны устгал хийх ажилд аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, ХХАА-н газрын бэлчээр хариуцсан мэргэжилтэн, сумын Засаг даргын орлогч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч царцааны хор цацах ажилд хяналт шалгалт хийж, ажлын дүгнэлт гаргасан.Царцааны хор цацах ажил 14 хоногийн туршид хийгдэж дууссан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, МҮОНТ-ийн хамтран зохион байгуулсан “Дөрвөн бэрх” нэвтрүүлэгт сумаас Засаг даргаар ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож урианхай ястны өв соёл, түүх, ёс заншлыг сурталчлах, түгээх үйл ажиллагааг тус нэвтрүүлгээр харуулсан.

Аймагт зохион байгуулагдсан Бий биелгээний улсын анхдугаар наадамд соёлын төвийн ажилчид болон сургуулийн 9 сурагч оролцож, 2 сурагч шагналт байранд шалгарсан амжилт үзүүллээ.

ЗДТГ-ын Мал эмнэлэг, үржлийн тасаг нь суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Нуман тамга” ТББ, сумын газрын даамал, БАХ-үүдийн ахлагч нартай хамтарч бэлчээрийн үр ашгийг дээшлүүлэх, эзэмших гэрээ байгуулах зэрэг ажлыг хамтран зохион байгуулан ажиллаж байна.

Сумын хөдөө аж ахуйн багуудын ИНХ-аас гарсан тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нар Хөхбэлчир, Шивэр багийн өвөлжөө, хаваржааны бүс нутагт буусан гадны сумын 18 малчин өрхөд мэдэгдэх хуудас өгч бэлчээр чөлөөлөх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

07 дугаар сарын 27-нд сумын Засаг даргын Тамгын газар болон Швейцарийн хөгжлийн агентлаг, Ховд аймгийн бэлчээрийн менежментийн холбоо хамтран сумын малчдын чуулга, уулзалт, сургалтыг зохион байгуулж, 4 багийн 200 гаруй малчид оролцлоо.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 13, эмнэлэгт хэвтэж гарсан хүний тоо 11, төрөлт суманд 2, аймагт 3, нас барсан хүн 1, гэрийн нас баралт 1, алсын дуудлага 12, эмчийн үзлэг 152, АД, ЧШ-гийн үзлэг 20, жирэмсний хяналтанд хамрагдсан 5, эхний 3 сартай хяналтанд 4, 4-6 сартай хяналтанд 1, элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо 20, товлолын вакцинд 18 хүүхэд хамрагдсан. Нийгмийн даатгалаас хөнгөлөлттэй олгох эмийн жорыг 25 хүнд бичиж олгосон.

**Зэрэг сум:** Аймагт зохион байгуулагдсан Улсын бие биелгээний анхдугаар наадамд сум нийт 30 хүний бие бүрэлдэхүүнтэй оролцсон ба насанд хүрэгчдийн ангилалд тэргүүн байр, бага насны хүүхдийн хамтлаг бүжгийн төрөлд тусгай байр эзэллээ.

Тулгар төрийн 2226, Их Монгол Улс байгуулагдсаны 811, Ардын хувсгалын 96 жилийн ойн аймгийн баяр наадамд тус сумаас 46 жилийн дараа азарга болон соёолон насны хурдан морины уралдаанд түрүү байрыг эзэлсэн ба нэг аймгийн начин шинээр төрлөө.

Сумын Засаг дарга, 5 багийн дарга нар мал аж ахуйн 4 багийн зуслангийн нутгуудаар явж ард иргэдтэй уулзалт хийлээ. Нийт нутгаар гандуу, өвсний гарц муу байгаатай холбогдуулан малын бэлчээр, хадлангийн талбайн ургацыг хамгаалах зорилгоор намаржаанд буух хугацаа, хадлангийн талбайн ургацаас шалтгаалан хадлан хадалтын өдрийг тогтоох захирамж гаргалаа. Малын бэлчээрийг хамгаалах зорилгоор Хойд шилд царцаа устгах ажлыг ЗДТГ-ын мэргэжилтэн Д.Чулуунтогтохоор ахлуулсан баг зохион байгууллаа.

Гүвээ болон Бургасан багийн хамтарсан өдөрлөг энэ сарын 22-ны өдөр Ханчдын дэнжид зохион байгуулж, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын ажилтан ард

иргэдэд Хүүхдийн хөдөлмөрийн талаар мэдээлэл хийлээ. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас “Малчдын хөдөлмөр эрхлэлт, тулгамдсан асуудал” сэдэвт сургалт өдөрлөгийг зохион байгууллаа.

“Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хэрэгжиж буй ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуургын ажилд сумын ЗДТГ-аас өдөр бүр хяналт тавин, ажлыг хэвийн явуулж байна.

Онцгой байдлын газрын дэргэдэх Зэрэг суман дахь Гал түймэр унтраах дугаар анги байгуулагдах Засгийн газрын шийдвэр гарсан ба уг албаны ажлын байрыг шийдвэрлэх болон тус ангид шинээр орох иргэдийг бүртгэж дууслаа.

**Манхан сум: Засаг даргын тамгын газар:**Сумын төвийн гудамж талбайг хайргажуулах зорилгоор 40 машин хайрга буулгаж, 2.4 километр замыг тэгшилж ажиллалаа.

Ардын хувьсгалын 96 жилийн ой, сумын үндэсний баяр наадмыг тусгай хөтөлбөрийн дагуу 07 сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Монголын Үндэсний Олон Нийтийн телевизийн “Дөрвөн бэрх” нэвтрүүлгийн зураг авалтанд оролцлоо.

Мөнххайрхан сум үүсгэн байгуулагдсаны 90 жилийн ойн баярын үйл ажиллагаанд оролцлоо.

Аймгийн ИТХ, Ногоон алт төслөөс зохион байгуулсан “Бэлчээрийн менежментийг сайжруулах нь” сургалтанд ИТХ-ын дарга, Засаг дарга, холбогдох, мэргэжилтнүүд оролцлоо.

**Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:** Нягтлан бодох бүртгэлийг бүрэн хөтөлж боловсруулан хагас жилийн тайлан гаргаж э-тайлан шивэв. Байгууллага болон сумын нэгдсэн 2018 оны төсөв 2019-2020 оны төсвийн төсөөлөл хийж тушаав. Спорт цогцолборын төсөв хийж, аймагт оруулж тушаан, бие даасан байгууллага болгох материал бүрдүүлэв.

**Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:** Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөнд оруулах саналын хэлэлцүүлгийг зохион байгуулахаар ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн 2 дахь санал хураалтыг зохион байгуулан ажиллалаа.

**Соёлын төв:** Аймагт зохион байгуулагдсан “Бий биелээчдийн улсын анхдугаар уралдаан”-д 35 хүний бүрэлдэхүүнтэй 5 хамтлаг, 8 гоцлол төрлөөр оролцож, “Таван хуруу” хамтлаг III байр, “Хөдөлмөр” хамтлаг II байр, “Захчин” хамтлаг III байр тус тус эзэлж өв тээгч Б.Бадамцэцэг “Шилдэг өвлөн уламжлагч”-аар шалгаран шилдгүүдийн Гала тоглолтонд оролцлоо.

Ардын хувьсгалын 96 жилийн ой, Манхан сумын Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлж, баяр наадмын нээлт, хаалтын арга хэмжээ, үдшийн цэнгүүнийг зохион байгуулж, морины бариа, наадмын талбайд узель ажиллуулав. Соёлын төвийн гадна, дотно орчинд жижиг урсгал засваруудыг хийлээ. 2017 оны 08 дугаар сарын 01-нээс бүх ажилчдын ээлжийн амралтыг олгоно.

**Эрүүл мэндийн төв:** Эрүүл мэндийн төв нь 4 их эмч, 22 ажилтан, нийт 26 орон тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. 07 дугаар сарын 26-ны байдлаар 494 хүнд үзлэг шинжилгээ хийсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгт 182 хүн хамруулсан ба эмнэлэгт 38 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна. Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртлэх 27 хүүхэд хамруулсан. 1 эх эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 13 дуудлаганд үйлчилсэн байна.

“Элэг бүтэн-Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд хамрагдвал зохих 795 хүнээс 308 хүн хамрагдсан байна. Үүнээс В-31, С-21, ВС-1 вирустай нийт 52 иргэн илэрсэн байна.

0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавин ажиллаж байна. Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд стандартын дагуу 210 нэр төрлийн эмээр үйлчилж, 90 хувийг тендэрээс авч хэрэглэж байна.

**Хөдөө аж ахуй, байгаль орчин:** 2016 оны Арьс ширний урамшуулал олгуулж, малчдын алдаатай данс засварлаж дээд шатны байгууллагад хүргүүлж, МЭҮН-үүд Бруцеллөз өвчний тандан шинжилгээнд 860 бог, 360 бод нийт 1220 малыг хамруулсан байна.

Сумын баяр наадам болж байгаатай холбогдуулан сумын төвийн гол дагуу морь уяж байгаа хүмүүстэй уулзан орчин тойрноо цэвэрхэн байлгах, хогоо хогийн цэгт хүргэж хаях талаар мэдээлэл өгч ажилласан.

Сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг гарч “Царцаа хоршоо”-ны царцааны устгал хийж байгаа газар дээр нь очиж үзлэг шалгалт хийж ажилд нь үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. 3500 га талбайд 700 литр хор цацаж ажилласан байна.

**Мөнххайрхан сум:** “Альпинад-2017” Монголын уулчдын улсын аварга шалгаруулах тэмцээн Мөнххайрхан ууланд 2017оны 06 дугаар сарын 29-нээс 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, уг арга хэмжээг аймгийн Биеийн тамир спортын газар, Онцгой Байдлын газар, тус сумын ИТХ, ЗДТГ, Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгууллаа. Дээрх арга хэмжээнд нийт 250 гаруй уулчид оролцож, ямар нэгэн байгалийн болон хүний зүйлээс шалтгаалсан осол гэмтэл гараагүй, хэвийн хэмжээнд зохион байгуулагдсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураалт явагдаж, санал хураалтанд иргэд 70 хувийн ирцтэй оролцлоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас ирүүлсэн тоотын дагуу 2017 оны 2-р ээлжийн цэрэг татлагын бүртгэлийг шинэчлэн гаргаж, хугацаанд нь хүргүүлэв.

07 дугаар сарын 19-нд зохион байгуулагдсан газрын даамал, эрх зүй, дотоод хэргийн ажилтнуудын сургалтанд холбогдох мэргэжилтнүүдийг бүрэн хамрууллаа.

Сумын түүхт 90 жилийн ой энэ сард товлогдсонтой холбогдуулан суманд Улсын баяр наадмыг 1 өдөр зохион байгуулахаар шийдвэрлэж, ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлээ.

Мөнххайрхан сум байгуулагдсаны түүхт 90 жилийн ой зохион байгуулахтай уялдуулан бэлтгэл ажлын хүрээнд сум орон нутгийнхаа тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах, ойн зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах, зочид, төлөөлөгчдийг хүлээн авах хотхон тохижуулах, зам харгуйгаа сайжруулах, Сэнхэрийн гол дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, сумын албан хаагчид, иргэдийг бүрэн хамруулж ажилласан байна.

Сумын түүхт 90 жилийн ойг ТВ-9 телевизээр шууд дамжуулан улс орон даяар цацсан нь ойн онцлох арга хэмжээнүүдийн нэг байсан юм.

07 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Урианхай сурын Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж, 205 харваач оролцсоноос Монгол Улсын мэргэн цолтон 12, үүнээс улсын эрхий мэргэн 1, улсын Дархан мэргэн 2, улсын хошой мэргэн 2 оролцож, Спортын мастер, дэд мастер цолтон 31 харваач тус тус оролцож, Улсын аварга 1, спортын мастер, дэд мастер цолыг 13 харваач хүртсэнээс тус сумын харваач спортын мастер Чийбаатар овогтой Жаргалсайхан түрүүлж Монгол Улсын аварга цол хүртэж, тус сумын иргэн харваач Ц.Ганболд, С.Очиржав, Ц.Энхболд, Б.Батзаяа нар спортын дэд мастерын болзол хангасан байна. Мөн багийн харваа зохион байгуулагдаж 13 баг харваачид оролцлоо.

Сумын хэмжээнд Засаг даргын тамгын газар, 12 жилийн сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Ус цаг уурын өртөө, Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа зэрэг төсвийн байгууллагууд урсгал засвараа бүрэн хийж дуусгасан төдийгүй ой угтсан ажлын хүрээнд дээрх байгууллагууд төдийгүй хувийн хэвшлийн бүх байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх иргэд гадна орчноо тохижуулах, хашаа хороогоо засаж сайжуулах бүтээн байгуулалтын ажлууд хийгдлээ.

**Мөст сум: Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны мэдээлэл:**

Сумын ИТХ-ын ээлжит IV хуралдааныг 06 сарын 30-нд зохион байгуулж ИТХ-ын 2017 оны хагас жилийн тайлан илтгэл, төсвийн тодотгол, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Баатархайрханы нурууг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай, “Жигүүр Алтай” нөхөрлөлөөр агнуурын менежмент хийлгэх, татвар орлогын төлөвлөгөөний 2016 оны дутууг хураасан байдал 2017 оны эхний хагас жилийн татварын орлогын явц, үр дүн, ан агнуурын төлбөр хураамжийн хэмжээг тогтоох тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж тогтоол гаргасан.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааныг 2 удаа зохион байгуулж, ИТХ-ын ээлжит IV хуралдааны тов зарлах, төрийн дээд шагналд тодорхойлох хүмүүсийн материал хэлэлцэх, 2018 оны төсвийн төсөөллийг хэлэлцэж шийдвэр гаргасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураалтыг зохион байгуулж сонгогчдын 50 гаруй хувь оролцож, амжилттай явуулсан.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлтийн талаарх хэлэлцүүлгийн ажлыг зохион байгуулж байна.

**Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл:** Сум нэгдсэн халаалтанд орохоор бэлтгэл ажил хийгдэж байна. Эхний ээлжинд төсөвт байгууллагуудыг холбохоор судалгааны болон бусад бэлтгэл ажлууд хийгдэж байна.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст нийтийг хамарсан ажлын төсөл хүргүүлж уг төслийн хүрээнд 10 иргэнийг ажиллуулж “Хашаа хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн сумын айл өрхийн хашааг шинэчлэх ажил хийгдэж байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилт босоо тэнхлэгийн замыг хөгжүүлэх төслийг гүйцэтгэгч замын компанийн холбогдох хүмүүстэй ярилцаж 2 техникийн /ковш, хово/ туслалцаа авч хуучин уурын зуухны хур хогийг цэвэрлэх ажлыг хийсэн.

Сумын Ардын хувьсгалын баяр наадмыг 07 сарын 10-11-ний өдрүүдэд тэмдэглэж өнгөрүүлсэн.

Суманд зохион байгуулагдаж байгаа аливаа баяр наадмыг мотоцикльгүй тэмдэглэх уриалгыг гаргаж уриалгыг ард иргэд сайн хүлээн авч сумын ардын хувьсгалын баяр наадмыг мотоцикльгүй тэмдэглэн өнгөрүүлсэн.

Завхан аймагт баруун 5 аймгийн ЗДТГ-ын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтанд хамрагдсан.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр 2 даатгуулагч хамрагдсан ба нийт 39 даатгуулагчийн 1255.9, эрүүл мэндийн даатгалд 15 даатгуулагчийн 590.8, нийгмийн даатгалын шимтгэлээр 3 байгууллагын 6900.9, нийт 8747.6 мянган төгрөгийн орлого орж орлогын төлөвлөгөө 37 хувьтай байна.

Сангаас 3 төрлийн тэтгэвэрт 2 арилжааны банкаар 101637.5, 3 нийт 102948.5 мянган төгрөг тавьж олгосон ба энэ сард тэтгэврийн сунгалт хөдөлгөөнийг 5 тэтгэвэр авагч хийлгэсэн ба шинээр 2 даатгуулагч тэтгэвэрээ тогтоолгосон байна.

**Мал аж ахуй, үйлдвэр үйлчилгээний чиглэлээр:** Сум бог малын хээлтүүлэгчээс бруцеллёз, үнээ 200. Ямаа 200 нийт 400 малаас сүүний дээжийн



шинжилгээ авсан. Мөн үхэр, адуу нийт 400 малаас сүрьеэ ямын шинжилгээ авсан. Бэлчээрийн менежментийн сургалтанд хамрагдсан.

**Байгаль орчин, газрын чиглэлээр:** Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үүрэг даалгаврын дагуу хяналт шалгалтын ажлыг нийт 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 300 гаруй ард иргэдэд байгаль орчны чиглэлээр мэдээлэл хийж ажиллалаа.

Манхан, Зэрэг сумын мал бүхий иргэдийг сумын өвөлжөө хаваржааны бүс нутгаас гаргах бэлчээрийн бүс нутгийг чөлөөлөх ажлыг зохион байгуулж, 80 гаруй малчин өрхийг өвөлжөөний бүсээс зуслангийн бүс рүү нүүлгэн шилжүүллээ.

Сумын төвийн хуучин уурын зуух, мөн эзэнгүй төвлөрсөн хог хаягдлыг 20 хоногийн хугацаанд цэвэрлэж хогийн цэгт хүргэлээ. Энэ ажлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилт босоо тэнхлэгийн замыг хөгжүүлэх төслийг гүйцэтгэгч замын компанийн техник хэрэгслээр ачиж гүйцэтгэлээ.

**Иргэний бүртгэл:** Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр нийт 7 иргэнд үйлчилсэн. Шинэ төрсөн 2 хүүхдийг бүртгэн гэрчилгээ олгож, шилжиж ирсэн 2 иргэнийг бүртгэлд оруулж, 3 иргэн шилжиж бүртгэлээс хасав.

**Соёлын төв:** Аймагт зохион байгуулагдсан “Бий биелгээний улсын анхдугаар наадам”-д амжилтай оролцож, Монголын тулгар төрийн 2226, Их монгол улс байгуулагдсаны 811, Ардын хувьсгалын 96 жилийн ойн баярын хурал, концерт, бүжиг цэнгүүн, Цэцэг гол багийн Шар булгийн овооны тахилга баяр наадмын бүжиг цэнгүүн, бүрэн дунд сургуулийг 1983-1993 онд, 1987-1997 онд төгсөгчдийн 20 жилийн ойн уулзалт баяр наадмын цэнгүүнийг амжилттай зохион байгуулан ажиллалаа.

**Эмнэлэг, эрүүл мэндийн чиглэлээр:** Нийт үзлэг 612 үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 457, гэрийн идэвхтэй хяналт- 123, дуудлагаар 34, жирэмсний хяналт-шинээр 4 хүнд үзлэг хийлээ.

Эмнэлгийн дотоодын сургалт -2, хүүхдийн зуны сувилал амжилттай ажиллаж нийт 68 хүүхэд хамрагдаж ,эцэг эхчүүдэд эрүүл мэндийн мэдлэг олгох сургалтыг 3 удаа явуулав.

**Мянгад сум: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаархи мэдээлэл:**

Тус сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 1 удаа хуралдаж, сумын улсын баяр наадмыг 07 дугаар сарын 10-11-ний өдөр Баянбулаг багийн Зуслан хүрэнд зохион байгуулахаар, зарим иргэдийг Төрийн дээд шагналд тодорхойлох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

**Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаархи мэдээлэл:** Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр 07 дугаар сарын 10-11-ний өдөр үндэсний их баяр наадмыг Баянбулаг багийн Зуслан хүрэнгийн талд Засаг даргын захирамжаар баяр наадам зохион байгуулах ерөнхий комисс, салбар комиссуудыг байгуулан баяр наадмын бэлтгэл ажлыг ханган амжилттай зохион байгуулан ажиллалаа.

**Санхүүгийн албаны үйл ажиллагааны талаархи мэдээлэл:** Орон нутгийн орлого 7 сарын байдлаар татварын орлого 18544,0 сая төгрөг төвлөрүүлж, 101.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг аван, 114.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаа. Сумын дунд хугацааны төсвийн төслийг боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлээд байна.

**Татварын чиглэлээр:** Аж ахуйн нэгж, байгууллагууд болон төсөвт байгууллагуудын тайлан шивэлтийг хянаж баталгаажуулан, төсөвт байгууллагуудын 2017-2019 оны төсвийн төсөл боловсруулан хүргүүллээ. 2017 оны эхний хагас

жилийн улирлын тайланг нэгтгэж аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлээ.

**Нийгмийн халамжийн чиглэлээр:** Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд тэжээгчээ алдсаны тэтгэмжинд нийт 20 иргэнд 2110.0, хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэрт 88 иргэнд 11220.0, ахмад настанг асарч буй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжинд нийт 43 иргэнд 2454.0, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжинд 101 иргэнд 3950,0 мянган төгрөгийн тэтгэмж тус тус олгосон байна.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Шимтгэлийн орлого 14541.0, Иргэний сайн дурын даатгалд 44 иргэнээс 4411.7, Эрүүл мэндийн даатгалд 51 иргэнээс 975.4, ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлд 9 иргэнээс 716,1 мянган төгрөгийн орлого орууллаа.

Мөн 4 иргэнээс тэтгэвэр тогтоолгох өргөдөл хүлээн авч хувийн хэрэг бүрдүүлж тэтгэвэр тогтоолтыг хийлээ. Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 77515.2 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврийг 283 хүнд 70241.1, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 29 хүнд 5011.8, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 60 хүнд 12970.2, ҮОМШӨ-ний сангаас 1 хүнд 285,5 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг тус тус олголоо.

**Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр:** Иргэний гэр бүлийн чиглэлээр энэ сард шинээр төрсөн 3 иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэж, Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан шилжин ирсэн болон явсан иргэний хүсэлт ирээгүй байна.

**ХАА, байгаль орчин үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын үйл ажиллагааны талаархи мэдээлэл:** МЭҮҮН-ээс гаргасан УМЭА-ны маягтын дагуу улирлын 17 төрлийн мэдээ, халдварт өвчний мэдээг 7 хоног тутам утсаар, сар бүр цаасан мэдээг нэгтгэн ХХААГ-ын Мал эмнэлгийн хэлтэст хүргэлээ.

Газрын харилцааны чиглэлээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газраа хамтран өмчилсөн иргэд, хамтран өмчлөх эрхээ салгуулахаар 4 иргэн, газар эзэмших 2 иргэн, газар өмчлөх 3 иргэн, нийт 9 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн байна. Газрын төлбөрт 3500.0 төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс 1750.4 мянган төгрөгийн орлогыг аймгийн Төрийн сангийн дансанд тушаалаа.

**Байгаль орчны чиглэлээр:** Мянгад суманд үйл ажиллагаа явуулж буй “Жаргалант рашаант”, “Тунгалаг Буянт”, “Од-Цэ” ХХК-ний үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа. “Жаргалант рашаант”, “Тунгалаг Буянт” ХХК-уудтай гэрээ байгуулахаар гэрээний төслийг боловсруулан ажиллаж байна.

Ардын хувьсгалын 96 жилийн ойн баяр наадам зохион байгуулж байгаатай холбогдуулан наадмын талбай болон гуанз, морины бариа орчимд хогийн савуудыг байрлуулж, баяр наадам зохион байгуулагдсаны дараа Засаг даргын Тамгын газрын ажилчид, байгаль хамгаалагч, Баянбулаг багийн дарга, манаач нарын хамт түүж, шатаан устгалаа.

Сумын мод үржүүлгийн талбай, “Чонон саарал”-ын цэцэрлэгт хүрээлэн, гудамны саад зэрэг сумын төвийн ногоон байгууламжуудыг сард 3-4 удаа тогтмол усалж байна. Мод үржүүлгийн талбай, “Чонон саарал”-ын цэцэрлэгт хүрээлэнгийн мод 70-80 хувьтай, гудамжны саадны мод 30-40 хувьтай ургаж байна

**Үенч сум:** Сумын Засаг даргын 2017 оны А/65 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд Сөнхөл зусланд Ардын хувьсгалын 96 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах ажлын хэсэг хурдан морь унаж уралдах хүүхдийн аюулгүй байдлыг хангах хариуцлагын гэрээ байгуулж хүүхдээ хурдан морь унахыг зөвшөөрсөн эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөл авч үндэсний их баяр наадмыг амжилттай зохион байгуулсан.

Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс бруцеллез өвчний шинжилгээнд 301 хуц ухнад цусны шинжилгээ, 340 ямаа, 182 үхэрт сүүн цагирган урвалын шинжилгээ хийгдлээ. Нарийн гол багийн Хужиртын хөрөлтийн ам нэртэй газарт үхсэн 2 янгирас эдийн дээж авч аймгийн мал эмнэлэг ариун цэврийн лабораторт хүргүүлж шинжлүүлж, колибактериоз өвчнөөр үхсэн нь оношлогдсон.

Цагаан түнгэ багийн нутаг дэвсгэр Улаан үзүүрт “МоЭнКо” ХХК-ны шинээр барьж байгаа гаалийн хяналтын талбайн ажилд 1 сарын хугацаатай гэрээ байгуулан 30 хүнийг түр ажлын байраар ханган ажиллаж байна.

Зуслангийн айл өрхүүдээр явж тарваган тахлын вакциныг нийт 558 хүнд хийсэн. “Тарваган тахлаас сэргийлье”, “Хуванцар савнаас татгалзья”, “Давсны хэрэглээг хязгаарлая” зэрэг сэдвээр бэлтгэсэн гарын авлага материалыг 180 өрхөд хүргэсэн. “Элэг бүтэн-Монгол” хөтөлбөрийн хүрээнд 40-65 насны 35 иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулан программд оруулсан.

Эрүүл мэндийн төвийн 80 жилийн ойг угтан урилга хийж тараах, номын материал хүлээн авч нэгтгэх ажлуудыг хийж байна.

**Ховд сум: Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:** Багийн Засаг дарга нарын сар бүрт хийх сургалт семинарыг өдөр зохион байгуулж 6,7 дугаар сард хийсэн ажлын чиглэлийн биелэлтийг тооцож, 8 дугаар сард хийх ажлын чиглэл хүргүүлэв.

Сумын Засаг даргын Тамгын газрын бичиг хэрэгт нийт 5 өргөдөл хүлээж авч шийдвэрлэх шатанд явж байна.

Сумын наадмын талбайг засварлах ажлын гүйцэтгэлд 2 удаа хяналт тавьж, гүйцэтгэлийг сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хүлээж авав.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн хэлэлцүүлгийг 07 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулав.

**Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого, газрын харилцааны хүрээнд:** Малын худалдаа, малын шилжилт хөдөлгөөнд болон мал сүргээ урьдчилан сэргийлэх вакцин, угаалга туулгалтанд хамруулж эрүүлжүүлсэн байдалд МЭҮТасаг, МЭҮНэгжүүд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Мөн тус сумын Баянбулаг багийн зуслангийн бүс болох Солоон хэмээх газарт 2016 оны 11 дүгээр сард малын цэцэг өвчин гарсантай холбоотой уг өвчний голомтын бүс нутгуудад мал амьтны шилжих хөдөлгөөн хийхгүй, 1 жилийн хугацаатай малчдыг зусаж болохгүй талаар ард иргэд, малчдад мэдэгдэн анхааруулж, 14 хоног хоногийн хугацаатай хяналтын пост гаргаж ажиллав.

**Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:** Сумын Эрүүл мэндийн төвд энэ сард 29 өвчтөн хэвтэж эмчилгээ хийлгэснээс Дотрын тасагт –18, эмэгтэйчүүд 1, төрөх 1, Хүүхдийн тасагт 6 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн байна. ЭМТ энэ сард алсын болон ойрын дуудлага -45, алсын дуудлага-35 байна. Мөн товлолын дагуу 47 хүүхдүүдийг вакцинд хамруулсан.

“Элэг бүтэн монгол үндэсний хөтөлбөрийн” хүрээнд 4 багт сургалт хийж 165 хүн сургалтанд хамрагдсан ба үүнээс шинжилгээнд 150 хүн хамрагдсан.

**Цэцэг сум: Засаг даргын Тамгын газрын хийсэн ажлын мэдээ:** Ерөнхийлөгчийн нөхөн сонгуулийн санал хураалтыг сумандаа амжилттай зохион явууллаа.

Засаг даргын Тамгын газарт 25 албан бичиг ирснээс хугацаатай 15, хугацаатай бичгийг цаг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна. Байгууллага, иргэдээс 5 өргөдөл гомдол ирсний хариуг хуулийн хугацаанд өгч ажиллалаа.

Тогтоол, шийдвэрийн биелэлтүүдийг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлж ажиллалаа.

ЗДТГ-ын хамт олон энэ сарын бүтээлч ажлын хүрээнд баяр наадмын талбай, ЗДТГ-ын хашааг будаж ажиллалаа. Нэгдсэн дулаан халаалтын ажил 40%-тай, Ахуй үйлчилгээний засварын ажил 50%-тай явагдаж байна. ЭМТ-ийн их засварын ажлыг эхлүүллээ.

07 дугаар сарын 11-нд Ардын хувьсгалын 96 жилийн ойн баяр наадам зохион байгууллаа. Баяр наадмаар 2 начин, 1 харцага, 1 заан шинээр төрлөө. Засаг дарга Эрүүл мэндийн төвийн 80 жилийн ойн баяр наадмын бэлтгэл хангахаар УБ хотод ажиллаж, амьдарч байгаа нутгийн зөвлөлтэй уулзалт зохион байгуулж, бүтээн байгуулалт, санхүүжилтийн ажлыг шийдвэрлэн ажиллаж байна.

7 дугаар сарын 16-17-нд Мянган угалзалтын цахир бүсийн овоо тахиж Дориг ургийн баярыг зохион байгуулав.

Баян-Овоо багт Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа, аймгийн ХХҮГазартай хамтарч малчдын чуулга уулзалтыг зохион байгуулж, малчдыг төсөл хөтөлбөрт хамрууллаа. Цагаан эрэгт нөхөн сэргээлт хийх ХХК-тай гэрээ хийв.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг тохиолдуулан 2 сарын аяны төлөвлөгөөг боловсруулан Баян овоо багийн Цагаан эрэгт Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг аяныг зохион байгуулж нийт 240 иргэд, 40 хүүхдэд сургалт зохион явууллаа.

Татварын улсын байцаагч хөдөөгийн 3 багаар явж орлого бүрдүүлж ажиллалаа. Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт дээр хяналт тавьж ажиллаа.

**Нийгмийн даатгал:** Сайн дурын даатгалд 96 иргэн, ЭМД 13 иргэн, жирэмсэний эхчүүд 6 хүнд, өндөр насны 4 хүн тэтгэвэр тогтоолгосон.

**Газрын алба:** 2 өвөлжөө, хаваржааны гэрчилгээ шинээр олгож, 1 өвөлжөө, хаваржааны гэрчилгээ нөхөн олгосон.

Сумын төвийн бүх айл өрхүүдийн хашааны газрыг кадастрт дээр тэмдэглэж, өвөлжөө хаваржааны судалгаа, эзэмшил, өмчлөл ашиглагчийн бүртгэлийг “Экситас” ХХК-д гарган явуулж, хаягжуулалтын сургалтанд хамрагдсан ба хаягжуулалтын тухай ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол гаргуулж, сумын төвийг хаягжуулж улс орон нутгийн чанартай авто замуудын хаягжуулалтын зургийн төсөл зэргийг хийж “Геокад” компанид өгч хамтран ажиллаж байна.

**Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр:** Шинээр төрсөн 6 хүүхэд, хугацаандаа бүртгүүлсэн 2, овог нэр өөрчлөлт 1, нас баралт 2, гэрлэлт 2 хөтөлж санд оруулсан. Иргэний үнэмлэхийн хугацаа сунгасан 34 иргэнээс 25 насны 12, 45 насны 20 иргэн байна.

**Эрүүл мэндийн төв:** Эрүүл мэндийн төвийн 80 жилийг ойг тохиолдуулан бүтээн байгуулалт, гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

**Соёлын төв:** Багуудад төлөвлөгөө гарган соёлын арга хэмжээг зохион байгуулж, ард иргэдийн идэвхийг сайжруулан, ЭМТ-ийн 80 жилийн ойн баяр наадмын урлагийн тоглолтын бэлтгэл ажлыг хангаж байна.

**Чандмань сум: Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:**

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 52 %-ын ирцтэйгээр хуралдаж, Засаг дарга, ИТХ-ын дарга нарын хагас жилийн тайлан, төсвийн тодотгол, татварын биелэлт, ЖДҮ-ийн тайлан зэргийг хэлэлцэн холбогдох асуудлуудыг хэлэлцэн тайлан мэдээнд дүгнэлт өгч, шийдвэр гаргалаа.

**Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл:** Сумын Засаг даргын Тамгын газар нь аппаратадын өргөтгөсөн зөвлөгөөнийг зохион байгуулан орон

нутагт хийгдэх цаг үеийн болон баяр наадмын бэлтгэл ажил хангах талаар асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ.

Монгол улсын Ерөнхийлөгчийн дахин санал хураалтыг амжилттай зохион байгуулснаар сонгогчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн 1803 сонгогчоос 1168 сонгогч санал өгч сонгуулийн ирц 64.78 %-тай явагдлаа.

Сумын Засаг дарга, Тамгын газрын даргын баталсан удирдамжаар байгуулсан ажлын хэсэг 2 удаа шалгалт хийж хэрэглээний баталгаат хугацаа дууссан 44 нэр төрлийн 297 ширхэг 858950 төгрөгний үнэ бүхий хүнсний барааг устгалын комиссын шийдвэрийн дагуу устгал хийж ажиллалаа.

Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах жилийн ажлын төлөвлөгөөний дагуу “Төрийн үйлчилгээ Таны багт” арга хэмжээг Сүлжээ багт зохион байгууллаа.

2017 оны хагас жилийн тоогоор 103196 төл хүлээн авсан амжилтаар Ардын хувьсгалын 96 жилийн ойгоо угтаж, “Түмэн адуу, буман хонины хишиг” малчдын баярыг тэмдэглэн өнгөрүүлж, малчин түмнээ алдаршуулан баярын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.

**Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр:** Иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд шинээр төрсөн хүүхэд 3, гэрлэлт-1, нас баралт-1, шилжин явсан-5, шилжин ирсэн-3, 25, 45 насны иргэдийн иргэний үнэмлэхийн сунгалт 3 иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

**Хөдөө аж ахуй:** Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын захирамжийн дагуу мал эрүүлжүүлэх, халдваргүйжүүлэх, мал эмнэлэг, ариун цэврийн сарын аяныг зохион байгуулж сумын 6 багийн мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг шалгалт хийж ажиллалаа. Боом 1473, ДХХ 10500, Дуут хавдар 2365, Коли бактериоз- 3186, Галзуу- 4250, Шөвөг 35400, Сахуу 1298, Сохор догол 38300, нийт 95474 мал вакцинжуулж, 36285 толгой малд боловсруулалт, малын хашаа буюу 75600 м<sup>2</sup> талбай, уст цэг 22 буюу 672 м<sup>2</sup>, тээврийн хэрэгсэл 150, зoorь агуулах 3 тус тус ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

**Нийгмийн халамжийн чиглэлээр:** Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд Амьжиргааг дэмжих зөвлөл 2 удаа хуралдсан. Хуулийн дагуу нийт 704 иргэнд 171914.0 мянган төгрөгийн халамжийн тэтгэвэр, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 66 иргэнд 25344.0, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжинд 118 иргэнд 27100.0, ахмад настны унааны зардалд 18 иргэнд 2730.0, хөгжлийн бэрхшээлтэй иргэний харилцаа холбооны зардал 3 иргэнд 160.0 төгрөгийн тэтгэмж өгч халамжийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үзүүлэн ажиллалаа.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Шимтгэлийн орлого 9627.3 мянган төгрөг, иргэний сайн дурын даатгалд 34 иргэнээс 2595.0, эрүүл мэндийн даатгалд 21 иргэнээс 861.1, нийт 13083.4 мянган төгрөгийн орлого орууллаа.

Мөн 4 иргэнээс тэтгэвэр тогтоолгох өргөдөл хүлээн авч хувийн хэрэг бүрдүүлж тэтгэврийн тогтоолтыг хийлээ.

Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 80436.0 мянган төрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврийг 258 хүнд 69769.9, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 12 хүнд 2767.0, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 33 хүнд 2767.0, ҮОМШӨ-ний сангаас 1 хүнд 262480 төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг тус тус олголоо.

**Эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр:** Эрүүл мэндийн төв нь нийт 108 амбулаторийн үзлэг хийж 18 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн.

Сумын Эрүүл мэндийн төв байгуулагдсаны түүхт 80 жилийн ой угтсан бүтээлч ажлууд, баяр наадмын бэлтгэл ханган байгууллагын дээврийн засвар, явган хүний зам, дотор тохижолтын ажлуудыг хамт олны оролцоотойгоор хийж гүйцэтгэн

хандив цуглуулах ажлыг шат дараатайгаар зохион байгуулан 20-23-ны өдрүүдэд баяр наадмыг зохион байгууллаа.

**Эрдэнэбүрэн сум:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураалтыг амжилттай зохион байгуулж, дүн мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлээ.

7 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд сумын Үндэсний баяр наадмыг амжилттай тэмдэглэн өнгөрүүлээ.

2017 оны ээлжийн амралтын хуваарийг баталж, 7, 8 сард ажилтнуудаа амрааж, 9 дүгээр сарын 10-ны өдөр гэхэд төрийн байгууллагын ажил жигдэрсэн байхаар тооцон ажиллаж байна.

Завхан аймагт болсон баруун бүсийн сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын цэргийн бэлтгэл сургалтанд хамрагдлаа.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Монгол улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл, Швейцарийн хөгжлийн агентлагийн “Ногоон алт” төслөөс хамтран зохион байгуулсан “Бэлчээрийн менежментийг сайжруулахад Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гүйцэтгэх үүрэг” сэдэвт 2 өдрийн сургалтанд сумын ИТХ-ын дарга, Засаг дарга болон холбогдох 6 мэргэжилтэн оролцлоо.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Шураг, Хонгио, Намарзан багуудад гэр цэцэрлэг ажиллуулж байна.

Цэргийн албыг дүйцүүлэх хэлбэрээр хаахаар аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 7 иргэнд сургалт зохион байгуулан үүрэг, чиглэл өглөө.

Бэлчээрийн зуслангийн бүс нутагт гантай байгаагаас Шураг, Хонгио, Намарзан багийн 30 гаруй малчдын 21000 толгой мал Баян-Өлгий аймгийн Толбо, Алтанцөгц, Баяннуур сумын нутагт отроор явж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Б.ГАНБОЛД